

# КОРОНАВИРУСЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЬЕ!

Монгол Улсынхаа төлөө зүтгэе!

Монгол Улсын 2010, 2013, 2014 оны салбарын шилдэг сонин



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.04.02 №13 (10690)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙХЭН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ГОЛ АЖЛЫГ НУГАЛЖ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцлаа

Улс орны хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчин, тэр дундаа барилгын цэрэг, инженерийн цэргүүдийн оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүрэг яндашгүй их. Энэ талаар олон ч хүнтэй уулзаж, амттай яриа өрнүүлж байсан цаг саяхан мэт. Тухайн цаг үед амьдарч байсан, бүтээн байгуулалтын гэрч болсон эрхмүүдээс сонссон түүх үеэс үе дамжин бидний дунд яригдсаар л байна. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын гол ажлыг Зэвсэгт хүчин нугалсан нь ч мөн түүхийн хуудаснаа хэзээ ч арилшгүйгээр, тодоор бичигдэж үлдэнэ гэдэг нь

дамжиггүй.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга, УИХ-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, УИХ-ын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нар холбогдох албаны хүмүүсийн хамт Дорноговь, Өмнөговь аймгуудад ажиллаж, үндэсний их бүтээн байгуулалт болсон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух барилгын ажлын явцтай танилцлаа.

(Үргэлжлэл нь III нүүрт)

## ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛОВ

Зэвсэгт хүчний Агаарын цэрэг болон Иргэний нисэхийн хамтын ажиллагааны зөвлөлийн ээлжит хурал боллоо. Энэ удаагийн зөвлөлийн хуралд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга, бригадын генерал Б.Батбаяр, ИНЕГ-ын тэргүүн дэд дарга Б.Алтанцол болон албаны бусад хүмүүс оролцож зөвлөлийн 2020 оны төлөвлөгөө, өнгөрөгч оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, цаашид авч хэрэгжүүлэх, хамтран ажиллах арга хэмжээг тодорхойллоо. Мөн Иргэний нисэхийн болон Улсын нисэхийн эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, "Чингис хаан" олон улсын нисэх буудлын хөөрөх, буух зурвасыг түр хугацаанд ашиглах, "МиГ-29УБ" сөнөөгч онгоцоор нислэг үйлдэх, ИНЕГ-ын зарим байгууламжийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн



командлалд олон улсын эрэн туслах хамтран зарим

шилжүүлэх, хайх, авран дадлага оролцох, нисэхийн тусгай тоноглолтой


техник хэрэгслүүдийг харилцан ашиглах зэрэг олон асуудлыг хэлэлцэж, зөвлөлийн 2020 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр болов.

## БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ОРОЛЦОХ ЦЭРГҮҮД МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИВ

Батлан хамгаалахын сайдын 2015 оны тушаалаар батлагдсан "Зэвсэгт хүчний ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2021"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мэргэжлийн ахлагч бэлтгэх төв нь зохих шалгууруудыг хангасны үндсэн дээр 17 тусгай мэргэжлээр сургалт явуулах эрхтэй болж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсролын газраас гэрчилгээ авсан юм. Үүний үр дүнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа томоохон бүтээн байгуулалтын ажлуудад нэн шаардлагатай тогооч, хүнд машин механизмын оператор, хүнд машин механизмын засварчин, гагнуурчин, зам гүүрийн мэргэжилтэн гэсэн таван тусгай мэргэжлээр 180 гаруй цэргийн алба хаагчийг амжилттай сургаж, төгсгөлөө. Тодруулбал, Зэвсэгт хүчний 15 анги, байгууллагаас ахлагчийн албанд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдыг өөрийн хүсэлтийг нь харгалзан энэхүү сургалтад 2019 оны 11 дүгээр сарын 1-нээс 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрүүдэд хамруулжээ. Тус сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Говьсүмбэр аймаг дахь Политехникийн коллеж, Налайх дүүрэг дэх Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын материаллаг баазыг түшиглэн хоёр үе шаттайгаар

зохион байгуулжээ.

"Энэ жилийн сургалтын онцлог нь цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжил эзэмшүүлэн ахлагчийн албанд элсүүлж, бүтээн байгуулалтад шаардлагатай



байгаа мэргэжлээр ажиллах нөхцөлийг нь бүрдүүлсэнд оршиж байгаа юм. Ингэснээр цэргийн алба хааж буй залуусын хувьд цаашид нийгэмд ажиллаж, амьдрахад нь томоохон түлхэц, хөрөнгө оруулалт болж байгаа төдийгүй нөгөө талаар Зэвсэгт хүчний ахлагчийн албаны нөхөн хангалтыг тодорхой хувиар өсгөж байгаа чухал ач холбогдолтой юм" гэж ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр онцоллоо.

Ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

## ХАМТАРСАН СУРГУУЛЬД ОРОЛЦСОН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



Монгол Улс, Катар улсын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд Катар улсад зохион байгуулагдсан хамтарсан сургууль, дамжаанд оролцсон 43 цэргийн алба хаагч Катар улсын Эмрийн Агаарын цэргийн хүчний тусгай үүргийн онгоцоор эх орондоо ирлээ.

Тэднийг Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу Цэргийн төв эмнэлэгт 21 хоног тусгаарлах юм.

## ХАНДИВЫН АЯН ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Монголчуудынхаа амь нас, эрүүл мэндийг сахин хамгаалахад хүчин зүтгэж, коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх эрсдэлтэй бүсэд

ажиллаж байгаа Цэргийн төв эмнэлгийн эмч, сувилагч, ажилтан албан хаагчид, тусгаарлалтад байгаа иргэдэд зориулсан хандивын аян үргэлжилсээр байна. Энэ удаад ЗХЖШ-ын Ахмадын хороо болон "Цэргийн холбоочид" Төрийн бус байгууллага тус бүр нэг сая төгрөгийг хандивлалаа. Үүнийг ЗХЖШ-ын Ахмадын хорооны нарийн бичгийн дарга, бэлтгэл хурандаа Д.Баатар, "Цэргийн холбоочид" ТББ-ын гүйцэтгэх захирал, бэлтгэл хурандаа Б.Төмөрбаатар, үндэсний зөвлөлийн гишүүд болох бэлтгэл хурандаа Д.Ганхуяг, Т.Баттөмөр нар Цэргийн төв эмнэлгийн Мэдрэлийн клиникийн харвалтын тасгийн ахлах эмч, ахмад Н.Золжаргалд гардуулан өглөө. Ахмад Н.Золжаргал "Шинэ коронавирусний халдвараас урьдчилан сэргийлэх талаар төр, засгаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг дэмжин, хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа Цэргийн төв эмнэлгийн бие бүрэлдэхүүнд сэтгэлийн хандиваа илгээсэн та бүхэнд баярлалаа. Бид энэхүү сэтгэлийн хандивыг тань халуун цэгт үүрэг гүйцэтгэж байгаа эмч, сувилагч, ажилтан алба хаагчид болон тусгаарлалтад байгаа иргэдэд нэн шаардлагатай зүйлсэд нь зарцуулах болно. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай" гээд хариу талархал гардуулсан юм.





## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЗЦ-ИЙН КОМАНДЛААС МЭДЭЭЛЖ БАЙНА

### КОМАНДАЛЫНХАН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГАА ДҮГНЭВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн 3 дугаар сарын 26-ны өдөр 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн тайлангаа дүгнэлээ. Хурлыг Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр удирдан явуулсан бөгөөд командлалын хэлтэс, тасаг, төрөл мэргэжлийн офицерууд тус бүрд нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, командлал, түүний нэгтгэл, ангиудад шинээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, анхаарах зарим асуудлын талаар танилцуулав. Тухайлбал, захиргааны удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого, сургалт, дадлагууд, цэргийн алба, сахилга бат, соёл хүмүүжил, хангалт үйлчилгээ зэрэг чиглэл бүрээр нь нэг бүрчлэн хэлэлцэж, дүгнэсэн. Хурлын төгсгөлд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар командлал, түүний нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүнд коронавирүсээс урьдчилан сэргийлэх, ажлын бүтээмжээ сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг чанд мөрдөх, сахилга, хариуцлагаа чангатган, илүү үр бүтээлтэй ажиллахыг үүрэг болгож, цэрэг халалт, таталт, хаврын тариалалт, бүтээн байгуулалт, сургалт, дадлагууд зэрэг олон ажил хүлээж байгааг анхааруулав.

### САХИЛГЫН ДҮНГИЙН ХУРЛААР ...

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын 2020 оны нэгдүгээр улирлын сахилгын дүнгийн хурал 3 дугаар сарын 26-ны өдөр болов. Командлал, түүний нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүний цэргийн алба, сахилга, дэг журам, харуул хамгаалалтын талаар Хуурай замын цэргийн командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн цэргийн албаны офицер, дэд хурандаа Н.Батжаргал танилцуулсан. Тэрээр "Хуурай

замын цэргийн нэгтгэл, ангиудын дэг журам, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай удирдлагын баримт бичгийг бие бүрэлдэхүүнд сурталчилж, сахилгын зөрчилгүй хамт олон бүрдүүлэх, зэвсэглэл, техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч ажиллалаа. Ялангуяа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга бат, дэг журмыг



бэхжүүлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажлуудыг тодорхой шатанд авч хэрэгжүүлж байна" гээд командлал, түүний нэгтгэл, анги тус бүрээр нь сахилгын дүнг танилцуулав. Үүний дараа Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр бие бүрэлдэхүүнд сахилга бат, дэг журмыг улам дээшлүүлж, ажлын цаг ашиглалтыг сайжруулан бүтээлч, санаачилгатай ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн юм.

Мөн 3 дугаар сарын 31-ний өдөр Захиргааны удирдлагын хэлтсийн нууцын офицер, ахмад Б.Лхагваа командлалын бие бүрэлдэхүүнд "Баримт бичгийн зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт" сэдвийн хүрээнд сургалт явууллаа. Тэрээр "Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт", "Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавигдах шаардлага", "Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдүүдийг байрлуулахад тавих шаардлага" зэрэг хэд хэдэн дэд сэдвээр задлан ярьсан юм. Энэхүү арга хэмжээний төгсгөлд Хангалт үйлчилгээний тасгийнхны санаачилгаар сайн үйлсийн аян өрнүүлж командлалын бүрэлдэхүүнд амны хаалт болон витамин тараав.

### Хошууч С.Энхтайван: БЯЛДАРЖУУЛАХ ТАНХИМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЖИГДЭРСЭН

ЗХЖШ-ын даргын тушаалаар батлагдсан "Биений тамирын бэлтгэлжилтийн норм, норматив"-ыг командлалын бие бүрэлдэхүүнд мөрдүүлэх, биений

жингийн зохистой харьцааг нь хангуулах зорилгоор өнгөрсөн оны 12 дугаар сард бялдаржуулах танхимыг шинээр байгуулсан. Тус танхимаар нэг дор 20 хүн зэрэг үйлчлүүлэх боломжтой бөгөөд бүх төрлийн дасгал, сургуулилт хийх техник, тоног төхөөрөмжөөр бүрэн



хангагдсан гэдгээрээ онцлог юм. Энэ талаар Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн биений тамирын офицер, хошууч С.Энхтайван хэлэхдээ "Командлалын удирдлагуудын зүгээс командлал болон нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүний биений тамирын сургалт бэлтгэлийг чанаржуулах, эрүүл мэнд,

бие бялдрын хөгжлийг дээшлүүлэхэд нь нэлээд анхаарч байна. Үүний нэг тод жишээ нь командлалын бялдаржуулах танхим юм. Бүрэлдэхүүний хувьд хэлтэс, тасгаараа ажлын таван өдөрт хоёр удаа 1-2 цаг бэлтгэл, сургалт хийх боломжтой. Өмнө нь ажлын таван өдөрт нэг удаа дасгал хийдэг байсныг саяхнаас хоёр болгож нэмэгдүүлсэн. Энэ нь биений жингийн зохистой харьцааг хангуулахад чухал үүрэгтэй юм. Мэдээж дасгал, сургалтыг хэд хэдэн төлөвлөгөөгөөр буюу биений жин хасах, нэмэх, бялдаржуулах, галбиржуулах гэсэн төрлүүдээр явуулж байна. Бие бүрэлдэхүүний хувьд ч маш их идэвх, чармайлттай дасгал, сургуулилыг гүйцэтгэж байгаа. Энгийн ажилтан алба хаагчид ч ялгаагүй биений тамирын хичээл, сургалтыг тасалдаггүй. Үүнээс гадна манай хэлтсийн зүгээс алба хаагчдын бие бялдрын хөгжлийг сайжруулах үүднээс сар бүр спортын уралдаан тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулдаг уламжлалтай. Гар дээр сунилт, гэдэсний таталт, дүүжинд сунаих дасгал зэргээр бүх алба хаагчдыг хамруулсан уралдааныг явуулж хэвшсэн" гэлээ. Дашрамд сонирхуулахад, алба хаагчдын дасгал, сургалтыг мэргэжлийн багш М.Баасанцэнд удирдан явуулдаг бөгөөд тэрээр бялдаржуулах танхимд зургаан жил багшилсан туршлагатай нэгэн юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

## "ХҮҮХЭД-ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ" АЯНД НЭГДЭЦГЭЭ

Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны тушаалаар жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийг "Олон улсын хэрэглэгчдийн өдөр" болгон тэмдэглэж байгаа билээ.

Энэ жил "Хүүхэд-Эрхэм хэрэглэгч" үйл ажиллагааг "Хүүхэд хэрэглэгч-Хүүхдийн эрүүл мэнд, цэвэр орчин" сэдвийн хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны хамтарсан тушаалаар 3 дугаар сарын 15-30-ны өдрүүдэд

хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, соёл гэгээрүүлэх, эрүүл, аюулгүй, зөв хэрэглээг гэр бүлд нь хэвшүүлэх, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилготой мэдээлэл, зөвлөмжийг түгээх арга хэмжээг зохион байгуулж байна.

Иймд Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн Та бүхнийг "Миний гэр-Аюулгүй орчин" үнэлгээний хуудасны дагуу гэрийнхээ орчин нөхцөлийг үнэлэх, хүүхдээ хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг уриалж байна.

Хошууч Э.БАТЖАРГАЛ

## АГААРЫН ЦЭРГИЙНХЭН ХӨХ ӨНГӨӨР "ИЖИЛСЭВ"



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн офицер, ахлагч нарын албаны хувцас, хүрмийн өнгийг хөх, албаны цамцыг цэнхэр өнгөтэй болгох шийдвэр нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгаж тэмдгийн загварт өөрчлөлт оруулах тухай" 175 дугаар зарлиг, ЗХЖШ-ын даргын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 595 дугаар тушаалаар баталсан "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-ээр батлагдсан боловч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжилт хүлээгдээд байсан юм. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг ЗХЖШ-ын Ар талын газар, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын санаачилгаар

зохион байгуулсан бөгөөд Агаарын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн эхний ээлжинд шинэ загварын хувцсанд бүрэн шилжлээ. Мөн Зэвсэгт хүчний 303, 337 дугаар ангиудын офицер, ахлагч нарыг 2020 оны 5 дугаар сард багтаан шинэ загварын хувцсанд шилжүүлэх, хангах ажлыг төлөвлөн ажиллаж байна.

Ийнхүү Зэвсэгт хүчний Агаарын цэргийн бүрэлдэхүүн хөх өнгийн дүрэмт хувцсанд шилжиж байгаа нь Агаарын цэрэг бие даан үүрэг гүйцэтгэх, үйл ажиллагааны онцлог, бусад төрлийн цэргээс ялгарах зэргийг илэрхийлэхээс гадна олон улсын жишигт нийцэж байгаа юм.

Ахмад Э.ОЧБАДРАХ

### Хилийн чанадаас

## ХУЯГТ ТЭЭВЭРЛЭГЧИЙН РОТ ХОШУУЧИЛЛАА



БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай "UN-MISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн ажиллагааны газар оронд ирээд хагас жилийн хугацааг ардаа орхиод байна. Энэ хугацаанд хамт олны хөлс хүч, хөдөлмөр зүтгэл, итгэл сэтгэл шингэсэн олон ажлыг нугалан НҮБ-ын мандатаар хүлээсэн үндсэн үүрэг нэр төртэй гүйцэтгэж, НҮБ, зорилго нэгт бусад орнуудын цэнхэр дуулгат дайчид, орон нутгийн иргэдийн дунд монгол цэргийн нэр хүндийг өндөрт өргөн, сайнаар дуурсгаж байгаа юм.

ИБНАУ

## САРЫН ТЭРГҮҮНҮҮДЭЭ ТОДРУУЛАВ



Цэргийн багийн хамт олон хагас жилийн хугацаанд хэрхэн ажилласан, юу хийж бүтээсэн хэлэлцэн тайлагнаж, алдаа, оноогоо дүгнэн ярилцаж үүрэг гүйцэтгэлт, сахилга, зохион байгуулалтаараа хамт олноо хагас жилийн хугацаанд манлайлсан тэргүүний салбараа шалгарууллаа. Энэхүү тэргүүний салбараар хошууч Н.Ганболд захирагчтай Хуягт тээвэрлэгчийн рот шалгарсан юм. Мөн 3 дугаар сарын тэргүүний штабын офицероор ахмад Э.Ганбаяр (150), тэргүүний салбарын офицероор дэслэгч Т.Отгондорж (150), тэргүүний штабын ахлагчаар сургагч ахлагч Д.Нямдаваа (084), тэргүүний салбарын ахлагчаар ахлагч З.Очирбат (350), дэд ахлагч Д.Оюунбаатар (ОБЕГ) нар шалгарав. Түүнчлэн тэргүүний шинийг санаачлагч, бүтээлч цэргийн алба хаагчаар ахлагч Э.Өлзийбаатар (011), тэргүүний эмэгтэй цэргийн алба хаагчаар ахлагч О.Батцэцэг (330), тэргүүний авьяаслаг цэргийн алба хаагчаар дэд ахлагч Д.Хишигдалай (ЦЕГ), спортоор манлайлагч цэргийн алба хаагчаар дэд ахлагч Г.Цэнд-Аюуш (350) нар тус тус шалгарч хамт олноо манлайллаа.

Ахмад Д.МЭНДБАЯР

## ЭЛСНИЙ ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНД ДЭД БАЙРТ ШАЛГАРЛАА

Румын улсын цэргийн алба хаагчаас зохион байгуулсан баазын аварга шалгаруулах элсний гар бөмбөгийн тэмцээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний хоёр баг, ХБНГУ, Бельги, Гүрж, Нидерланд, Латви, Унгар зэрэг орны эвслийн цэргийн алба хаагчаас бүрдсэн 24 баг оролцож, хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Энэхүү тэмцээнд дэслэгч Г.Гантулга (084), ахлагч А.Биндэръяа (032), дэд ахлагч Б.Батмөнх (123), дэд ахлагч Ц.Мөнхболд (338) тамирчидтай баг хоёрдугаар байрт шалгарч дурсамж, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

Ахлах дэслэгч Д.ХАШХҮҮ



### Редакцын шууданд

#### 013 дугаар анги

ЗХЖШ-ын Ар талын газраас зохион байгуулж байгаа хугацаат цэргийн алба хаагчдын хоолны орц, нормыг шинэчлэх, туршилтын төсөлтэй холбогдуулан ЗХЖШ-аас томилогдсон албан тушаалтнууд өдөр бүр хоолны амт чанар, боловсруулалтыг шалган зохих зааварчилгааг өгч ажиллаж байна. Мөн энэхүү арга хэмжээний үеэр хоёр удаа социологийн судалгааг явууллаа.

Хошууч Ж.ТӨГСМАНДАХ

#### 331 дүгээр анги

Дэлхий дахинд хор хөнөөл учруулж буй цар тахал "Covid-19" вирусийн эсрэг ангийн удирдлага, бие бүрэлдэхүүн "Бид нэг дэлхий" уриатайгаар Баян-Өлгий аймгийн Онцгой комисст 500,000 төгрөг хандивлалаа. Мөн тусгаарлагдаж буй иргэдэд 80 ширхэг ор хэрэглүүлж, ангийн дотоод нөөц бололцоогоор амны хаалт оёж, бие бүрэлдэхүүнд үнэгүй тараах ажлуудыг зохион байгуулав.

Дэслэгч Л.БОЛД

# ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ГОЛ АЖЛЫГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙХЭН НУГАЛЖ БАЙНА

(Түрүүч нь I нүүрт)

Мөн алба хааж буй цэргүүдтэй уулзаж, санал сэтгэгдлийг нь сонссон бөгөөд цэргүүд эх орныхоо бүтээн байгуулалтад гар бие оролцож, халагдаад харихдаа мэргэжлийн чиг баримжаатай, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болж байгаадаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байсан юм.

Дорноговь аймгийн Зүүнбаян талаас Зэвсэгт хүчний анги суурь бүтэц, хиймэл байгууламжийг гүйцэтгэж байгаа ба одоогоор ажлынхаа 80 гаруй хувийг нугалж, төлөвлөгөөт хугацаанаас нь өмнө дуусгахаар ажиллаж байна.

Энэхүү төмөр зам ашиглалтад орсноор трассын дагуух Цагаан суварга, Хармагтай зэрэг стратегийн 30 гаруй том орд эдийн засгийн эргэлтэд орж, монголчууд үр өгөөжийг нь хүртэх боломж бүрдэх аж.

Зэвсэгт хүчний 7781 дүгээр ангийн захирагч, бригадын генерал



Бэлтгэл хурандаа Н.Ренчин-Очир

хувьд хуучнаар ЗХУ-ын Одесс хотын Цэргийн инженерийн дунд сургуулийг төгсжээ. Ингээд 1985-1989 онд Зүүнбаян дахь Танкийн хороонд сапёрын салааны даргаар дөрвөн жил алба хаасан. Гучин жилийн дараа ажил, амьдралынхаа гарааг эхлүүлсэн энэ газарт эргэн ирж бүтээн байгуулалтад оролцож байгаагаа хувь тохиол гэж боддог, бас бахархдаг аж. Түүний хамгийн сайн туслагч нар нь МСҮТ-ийг төгссөн шинэхэн ахлагч нар. Харин тэд төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаадаа хэр сэтгэл хангалуун байгаа талаар хожим өгүүлэх болно.

Бэлтгэл хошууч Л.Батбаярын хувьд 7780 дугаар ангийн нэгдүгээр салааны инженерээр ажиллаж байна. Тэрээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дахь авто замын бүтээн байгуулалтын ажилд хоёр жил гаруйн хугацаанд оролцсон. Залгуулаад төмөр замын бүтээн байгуулалтад оролцохоор энд иржээ. Тэрээр "Хэрэгтэй гэвэл өөрт байгаа мэдлэг, чадвар, нөөц бололцоогоо эх орныхоо төлөө, хаана ч, хэзээ ч дайчлахад бэлэн. Залуустайгаа эргээд уулзах сайхан байна" гээд ажлынхаа талаар танилцууллаа. Энэ хэсгийн гол ажил бол даланг барихад лабораторийн шинжилгээнд орсон материалаар бүрэн хангах үүрэгтэй. Энэ үүрэг эг биелүүлэхийн тулд төрөл бүрийн техник хэрэгслээр 24 цагийн турш тасралтгүй хоёр ээлжээр үүрэг гүйцэтгэж,



Бэлтгэл хошууч Л.БАТБАЯР

бэлдцээр хангадаг байна. Өдөр бүрийн төлөвлөгөөт ажлаа бүрэн гүйцэтгэж байгаа гэдгийг алба хаагч нэг бүр хэлж байв.

Зэвсэгт хүчний 7782 дугаар ангийн гүүр хоолойн хэсгийн дарга, хийцийн инженер, бэлтгэл дэд хурандаа Ц.Ганбат 202, 234, 256 дугаар ангийн салааны захирагч, захирагчийн нэгдүгээр орлогч, штабын даргын албыг хашиж байсан туршлагатай нэгэн аж.



Дэд хурандаа Ц.ГАНБАТ

Тэрээр МСҮТ төгсөж ирсэн шинэхэн ахлагч нарын талаар "Бүтээн байгуулалтын ажилд оролцохоор ирсэн залуус маань шанагат эксковатор, автогрейдрийн оператор зэрэг мэргэжлээр бэлтгэгдсэн. Их азтай залуус юм. Төмөр замын бүтээн байгуулалтын явцад тэдэнд олон боломж нээгдэж байгаад би их баяртай байна.



Далангийн бүтээн байгуулалтын бэлдцийн ажил хийгдэж байна

Одоогоор ахлагч нарыг гүүр хоолойн хийц угсрах ажилд дадлагажуулж байна" гээд инженерийн цэргийн нэр хүнд үеийн үед өссөөр байгаад сэтгэл хангалуун явдгаа илэрхийлсэн. Мөн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд амжилт хүсэн, эрхэлсэн ажилдаа эзэн байхыг уриалав.

## БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ БА ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ ИРГЭН

МСҮТ-ийг замчин мэргэжлээр төгссөн энэ залууг дэд ахлагч Б.Аяболат гэдэг. Тэрээр гүүр хоолойн хэсэгт өнгөлгөө, тэгшилгээ зэрэг чимхлүүр ажлыг хийж гүйцэтгэдэг бөгөөд "Онолын мэдлэгээ баталгаажуулж, үеийн нөхөд, ахмадуудаасаа танхимын сургалтаас олж авч чадаагүй шинэ зүйлсийг сурч мэдсээр байгаадаа сэтгэл хангалуун байна" гэсэн. Түүний хувьд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид алба хаадаг. Хилийн цэрэгт алба хаадаг ах нь Б.Аяболатад хамгийн их үлгэр дуурайл үзүүлж, цэргийн хүн болох хүслийг нь өдөөж өгчээ. Харин Зэвсэгт хүчинд алба хааснаар энх цагийн бүтээн байгуулалтад оролцох боломж нээгдсэн байна. "Хэрвээ хөдөө гэртээ урьдынх шигээ өдөр хоногийг өнгөрөөсөн хэвээрээ байсан бол ийм олон боломжийн үзүүрээс нэгэн зэрэг атгаж чадахгүй. Би давхар мэргэжилтэй, мөнгөн хуримтлалтай болсон. Миний үеийн залуус ийм л зүйлийг хүсэж мөрөөддөг. Төмөр замын



Дэд ахлагч Б.АЯБОЛАТ

бүтээн байгуулалтад оролцох болсон гэдгээ гэрийнхэндээ дуулгахад тэд их баярласан, бас их магтсан. Аав, ээж хоёр маань надад "Зэвсэгт хүчин миний хүүг тангараг өргөсөн эр цэрэг болгосон бол одоо хаана ч өөрийгөө тордоод явчих ажлын дэргтэй болголоо" гээд их олзуурхсан. Гайхуулж хэлээд би их азтай хүн" гэж инээмсэглэсээр дэд ахлагч Б.Аяболат хийж байсан ажлаа үргэлжлүүлээ.

Дэд ахлагч Д.Батцэнгэл анх төмөр замын бүтээн байгуулалтад оролцох хугацаат цэргийн алба хаагчдыг МСҮТ-д сургаж байгаа талаар дарга нараасаа



Дэд ахлагч Д.БАТЦЭНГЭЛ

сонсжээ. Халагдах өдрөө тоолон хүлээж байсан хэдий ч өөрийн хүсэлтээр МСҮТ-д хүнд машин механизмын оператор ажлын талбарт гараад байгаа нь энэ аж. "Зүгээр л халагдчихсан бол дараа нь өөртөө харамсах байсан биз. Мэдээж энэ бүхний эхлэл нь цэргийн зарлан дуудах хуудас ирсэн өдөр байсан. Одоо бодоход их бүтээн байгуулалтад дуудагдсан өдөр ч юм уу даа гэж бэлгэшээдэг. Багаасаа машин, техникийг сонирхдог байсан учраас энэхүү мэргэжлээр суралцсан. Монгол Улсын түүхэнд урьд өмнө нь хийгдэж байгаагүй том бүтээн байгуулалтад гар бие оролцож байгаадаа сэтгэгдэл өндөр байна. Дараа нь найз нөхөд, үр хүүхдүүддээ ярихад ч нүүр бардам шүү дээ" хэмээн жолоогоо мушгингаа үргэлжлүүлэн ажлынхаа онцлогийг танилцууллаа. Дэд ахлагч Д.Батцэнгэл өдөр тутамдаа далангийн шороог тэгшлэх ажлыг хийж гүйцэтгэдэг. Овоолсон шороог нааш цааш тараах мэт энгийн л нэг дүр зураг харагдах хэдий ч дараагийн үйл явц буюу автогрейдерээр индүүдэхэд бэлэн болгож, бусдынхаа хөдөлмөрийг хөнгөвчилж байгаа нь тэр аж.

## ЦЭРГИЙН НӨХӨРЛӨЛ ХАМГИЙН ҮНЭ ЦЭНТЭЙ

Ажилсаг бас үргэлж инээмсэглэх энэ байлдагчийг Б.Цэрэнпунцаг гэдэг. Зэвсэгт хүчний 256 дугаар ангиас хэсэг нөхдийн хамт төмөр замын бүтээн байгуулалтын ажилд томилогдон иржээ. Түүний



Зүүн гар талаас байлдагч Б.ЦЭРЭНПУНЦАГ, Б.ОЮУНБААТАР нар

хувьд ангидаа харуул манааны үүрэг гүйцэтгэж сурсан тул шөнийн ээлжинд гарахад бэрхшээлтэй зүйл байдаггүй. Найз Б.Оюунбаатартайгаа хамт дохиочин хийдэг. "Улс орны бүтээн байгуулалтад оролцож, зохих хувь нэмрээ оруулж байгаадаа өөрийгөө их азтайд тооцдог. Энэхүү төмөр зам баригдаж дууссаны дараагаар экспорт нэмэгдэж, улсын эдийн засаг өсөн, хөгжил улам хурдасна гэдэгт би итгэдэг. Тиймээс өөрийн хийж байгаа ажилдаа их хариуцлагатай хандахыг хичээдэг" гэх хэрсүү яриатай, шавилхан биетэй байлдагчийг хараад бахархах сэтгэл төрнө. Харин дээр дурдсан Б.Оюунбаатар гэх байлдагч түүний хамгийн дотнын анд, сайн зөвлөгч нь. Тэд хамтдаа цэрэгт татагдаж, нэг ангид алба хааж, бүтээн байгуулалтад гар нийлэн ажиллаж байгаа энэ цаг үе нь бидний нөхөрлөлийг гэгээлэг гинж шиг бат болгосон гэж дуу

нэгтэй хэлэх юм билээ. Мөн манай сониноор дамжуулан аав, ээж, ах, дүү нартаа болон он жавууддаа "Албаа хаахын зэрэгцээ ажилд дөртэй болж, хуримтлал үүсгэн, ирээдүйдээ том хөрөнгө оруулалт хийж байна. Аав, ээж хоёр минь, захиас номыг тань сайн биелүүлж байгаа. Та бүгдийнхээ итгэлийг алдахгүй. Бидэнд санаа зоволтгүй, халагдаад очих хүртэл баяртай" гэж бүтээн байгуулалтын талбараас мэндчилснийг нь уламжилж байна.

## ЦӨӨН ДУРСАГДДАГ Ч ...



Л.МӨНХЦЭЦЭГ

Тангараг өргөөгүй ч хариуцлагатай үүрэг хүлээсэн хүмүүс бол цэргийн тогооч нар бөгөөд тэд Зэвсэгт хүчний ар талын амин чухал асуудлуудын нэг болох хоол, хүнсний зэрүүл ахуйг бүхэлд нь хариуцдаг онцлогтой. Энэхүү бүтээн байгуулалтын ажилд ч тогооч нарын үүрэг, оролцоо өндөр байгаа гэдгийг харуулахыг хүслээ. Учир нь тэд ихэнхдээ магтаал, сайшаалын ард хоцорч үлддэг гэдэгтэй маргах хүн цөөн биз ээ. Гал зуухнаас холдолгүй аяга таваг, халбага сэрээ хангинуулсаар үүрийн таван жингээс үдшийн бүрий хүртэл цурам хийх ч завдалгүй хөдөлмөрлөдөг хүмүүс бол яахын аргагүй тэд мөн. Л.Мөнхцэцэг Зэвсэгт хүчний 110 дугаар ангиас бүтээн байгуулалтад томилогдсон. Түүний ажил 04.00 цагаас эхэлдэг. Бие бүрэлдэхүүнийг өглөөний цайнд оруулсны дараагаар цэвэрлэгээ, хүнсний бэлдэц зэрэгт анхаарал тавьж нэг л мэдэхэд үдийн хоолны цаг хаяанд тулаад ирнэ. Өдрийн хоолноос оройн хоол хүртэл ажил бас л ундардаг. Ёстой л биеэ хэд хуваах вэ гэгч л болно. Ингээд 23.00 цаг амрах хэдий ч 04.00 цагаас цэрэг дурдсан бүх ажил ахиад л үргэлжилнэ. Гэхдээ цэргийн тогоочийн нэг онцлог нь ямар ч нөхцөлд, хаана ч, хэзээ ч үүрэг гүйцэтгэх чадвартай, бие болоод сэтгэл зүйн хувьд бэлтгэгдсэн хүмүүс байдаг учраас ажлыг их гэж яндаж, халширч үзээгүй гэдгийг бид мэдэх билээ.

Төмөр замын бүтээн байгуулалт болон үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний талаар товчхон танилцуулахад ийм буюу.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ



Бригадын генерал П.ДОРЖСҮРЭН

П.Доржсүрэнгийн хэлснээр, алба хаагчдын хувьд МСҮТ-үүдээр бэлтгэгдэж оператор, жолооч зэрэг мэргэжил эзэмшиж байгаа нь Зэвсэгт хүчний боловсон хүчин улам чанаржиж байгаагийн нэг илрэл аж. Мөн тэрээр "Монгол Улсын Зэвсэгт хүчин төмөр замын бүтээн байгуулалтад хоёр дахь жилдээ үүрэг гүйцэтгэж байна. 2019 онд Зэвсэгт хүчний ангиуд маань өмнөө тавьсан зорилго, зорилтоо ханган ажилласан. 2020 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс бүтээн байгуулалтын ажилдаа эргээд орсон. Энэ их ажлын хүндийг Зэвсэгт хүчин маань нуруундаа үүрч байна. Манай анги, байгууллагууд шинэ боловсон хүчин, техник хэрэгслээр сайн хангагдсан. Бүтээн байгуулалтын талбарт байгаа алба хаагчдынхаа гэр бүлийнхэнд нь бас талархал илэрхийлье. Танай хүү, нөхөр, эхнэр, аав, ээж гээд бүгд л үлгэр жишээчээр ажиллаж байгаа гэдгийг хэлье" гэсэн юм.

## АВЬЯАС ТЭТГЭВЭРТ ГАРДАГГҮЙ

Мэдлэг, ур чадвар гэдэг тухайн хүний насан туршийн өмч. Гэхдээ өмчилнө гэдэг нь хав дарчхаад ил гаргахгүй байна гэсэн үг биш. Үе үеийн барилгын цэрэг, офицер, инженерүүд өөрсдийн сурч мэдсэнээ өвлүүлэх, уламжлуулах талаар их гойд хүмүүс шиг санагддаг. Ер нь тэдний арвин туршлагаас хаях юм нэгээхэн ч үгүй. Энэ ч утгаараа Зэвсэгт хүчин бэлтгэлд байгаа ахмадуудаа бүтээн байгуулалтын талбарт эргэн дуудаж, эх орныхоо төлөө ахин зүтгэх үүрэг даалгавар өгчээ.

Бэлтгэл хурандаа Н.Ренчин-Очир 7781 дүгээр ангийн гүүр хоолойн хэсгийг ахалж байна. Тэрээр ажлын явцын талаар "Зүүнбаянгаас эхлээд 13 гүүр хоолойн ажил хийгдсэн. Өнгөлөх, будах зэрэг чимхлүүр ажил явагдаж байна. Үндсэн ажил дуусмагц далангийн бүтээн байгуулалт явагдаж байх. Мөн Мандах чиглэлийн 20 км төмөр замын хэсэг рүү хэмжилтийн багаа явуулсан. Тус газарт ч бас гүүр хоолойн ажил хийгдэнэ. Зарим хоолойг нь Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн томилгоот бие бүрэлдэхүүн угсарч байна. Одоогоор ажил 90 гаруй хувьтай байгаа" гэв. Уншигч танд сонирхуулахад, түүний



# НИЙСЛЭЛИЙН МЭНДЧИЛГЭЭ



Аливаа улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс нь батлан хамгаалах бодлого байдаг билээ.

Монгол Улсын хувьд батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг орон нутагт сурталчилж, хэрэгжүүлэх байгууллага нь Цэргийн штаб юм.

Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлж байгаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабыг тэртээ 95 жилийн өмнө буюу Улаанбаатар хотын Захиргааны төлөөлөгчдийн 1925 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 2 дугаар хурлын 3 дугаар тогтоолоор Цэргийн хэлтсийг эрхэлсэн түшмэл, туслах түшмэл, тасгийн дарга, гурван бичээч бүхий нийт зургаан хүний орон тоотойгоор байгуулжээ.

Цэргийн яамны Дайчлан зохион байгуулах хэлтсийн байнгын удирдлагын дор Цэргийн хэлтэс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн тухай Улаанбаатар хотын даргын 1925 оны 140 тоот албан бичигт "Хотын захиргааны хэрэг эрхлэх газраас Цэргийн хэлтсийг нээж, хэрэг

шийтгэсэн ба харьяат цэрэг эрийг бүртгэх учир болзоолон зохих газруудад зарлан мэдэгд" гэсэн түүхэн баримт байдаг.

Ингэж Улаанбаатар хотын захиргааны бүтцэд түүхийн хуудсаа эхлүүлсэн Цэргийн штаб /хэлтэс/ маань батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэхдээ 12 удаа нэрээ сольж, одоо Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Цэргийн штабын дүрэм"-ийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийслэлийн Цэргийн штабаас сүүлийн жилүүдэд түүхээ судалж 2013 онд "Нийслэлийн цэргийн штабынхан" ном хийсэн бол энэ жил Цэргийн штабын 95 жилийн ойгоор "Улаанбаатар хотын Цэргийн штабын түүхэн замнал" гэсэн баримтат кино, "Нийслэлийн Цэргийн штаб" гэсэн гэрэл зургийн цомгийг тус тус бүтээгээд байна.

Нийслэл Улаанбаатар хотын эрт, эдүгээгийн үүсэл, хөгжил дэвшилд

цэргийнхэн болон Цэргийн штабын гүйцэтгэсэн үүргийг үнэлж баршгүй. Улаанбаатар хотын шинэ цагийн бүтээн байгуулалтуудад цэрэг дайчид гар бие оролцож байгаа билээ.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, бүтээн байгуулалтын ажил, хөгжил дэвшлийн талаар дэвшүүлсэн санал, санаачилгыг Батлан хамгаалах яам хүлээн авч, хүн хүч, техникийн дэмжлэг, тусалцаа үзүүлэн хамтран ажиллаж байгаад талархаж байгаагаа энэ дашрамд илэрхийлж байна.

Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг 95 жил сурталчилж, Батлан хамгаалах салбарыг Нийслэлтэй холбож гүүр болж байгаа Цэргийн штабын хамт олон, Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч болон Нийслэлийн нийт иргэдэд баярын мэнд хүргэе.

Монгол цэргийн сүлд, хийморь үеийн үед мандан бадрах болтугай!

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

## ЭРТ ЭДҮГЭЭГ ХОЛБОСОН 95 ЖИЛ

1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр хуралдсан Улсын анхдугаар Их хурлын тогтоолоор Нийслэл хүрээг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нийслэл хэмээн зарлаж, нэрийг нь "Улаанбаатар хот" гэж нэрлэн, Улаанбаатар хотын Захиргааны газрыг 20 орон тоо, дөрвөн хэлтэстэйгээр зохион

орон даяар өрнөхөд хотын Цэргийн хэлтэс манлайлан оролцож, хотын иргэдийн дунд ухуулга таниулга хийж, Зөвлөлтийн ард түмэн, дайчдад илгээх бэлгийн цуваа, агт морьд, дулаан хувцас, хүнс бэлтгэх, Монголын ард түмний хандивын хөрөнгөөр "Монгол ард" нисэх эскадриль, "Хувьсгалт Монгол"

Сэрээтэр /1931, 1936-1937 он/, дэд хурандаа Бямбажавын Батсүх /1944-1950, 1951-1954 он/, хурандаа Нансалмаагийн Сүхбаатар /1961-1964, 1971-1980 он/ нар хоёр удаа томилогдон, хурандаа Н.Сүхбаатар 13 жил, дэд хурандаа Ч.Санжжав 10 жил, хурандаа Л.Доржсүрэн 14 жил Цэргийн штаб /хэлтэс/-ын даргаар



байгуулж, бие даасан төсөв санхүүтэй болгох дүрмийг баталжээ.

Энэхүү шийдвэрийн үндсэн дээр 1925 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр хуралдсан Улаанбаатар хотын захиргааны төлөөлөгчдийн хоёрдугаар хурлын гуравдугаар тогтоолоор Улаанбаатар хотын Цэргийн хэлтсийг эрхэлсэн түшмэл, туслах түшмэл, тасгийн дарга, бичээч гурав, бүгд зургаан хүний орон тоотой байхаар тогтжээ.

1925 онд Улаанбаатар хотын анхны Цэргийн хэлтсийн эрхэлсэн түшмэлээр Дэлхэвийн Сандуйжав, тасгийн даргаар Лувсандэндэв, бичээчээр Батмөнх, Жижидсүрэн, Лхамжав нарыг томилжээ.

Улаанбаатар хотын Цэргийн хэлтэс нь 1925 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж, мөн оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хотын харьяат цэрэг эрсийг бүртгэж эхэлжээ. Улаанбаатар хотын Цэргийн хэлтэс нь үүсэж байгуулагдсан өдрөөсөө эхлэн ардын төр, Засгийн газар, Цэргийн яамны дүрэм, тушаалыг иргэд, малчин олон түмэнд сурталчлан таниулах, улс эх орныхоо батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэхэд иргэдийн оролцоог сайжруулах, цэрэгт яваагүй цэргийн өмнөх насны залуучуудад цэргийн анхан шатны сургалт, бэлтгэлийг хотын хэмжээнд цугларалтаар зохион байгуулах, жилд хоёр удаа эрүүл чийрэг, идэр насны залуучуудыг цэргийн албанд татаж, Монгол Ардын Хувьсгалт цэрэг /МАХЦ/-ийн эгнээг өргөтгөх, цэргийн албан хаагчдын ар гэрт халамж, үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж байлаа.

1939 оны Халхын голын болон 1945 оны Чөлөөлөх дайн, 1947-1948 оны Баруун хилийн тулгаралтын үед Улаанбаатар хотын Цэргийн хэлтсийн даргаар ахмад Жүрмэдийн Ёндон, дэд хурандаа Бямбажавын Батсүх нар ажиллаж, "Бүхнийг ялалтын төлөө" уриан дор фронтод байлдаж байсан МАХЦ-ийн бүрэлдэхүүн, Зөвлөлтийн армид туслах хөдөлгөөнийг өрнүүлэн хоол хүнс, дулаан хувцас, бензин түлш, агт морьд, зэвсэг, техник, галт хэрэгсэл, эм, тариагаар хангах ажлыг тасралтгүй зохион байгуулж, төр, засаг, армийн командлалаас өгсөн үүрэг даалгаврыг нэр төртэй биелүүлж байжээ.

1941-1945 онд Дэлхийн хоёрдугаар дайны фронт дээр тулалдаж байсан Зөвлөлтийн улаан армид туслах хөдөлгөөн Монгол

танкийн бригадыг зохион байгуулж Зөвлөлтийн армид бэлэглэх ажилд идэвхтэй оролцсон юм.

1939, 1945 оны дайны жилүүдэд МАХЦ-ийг байлдааны цагийн орон тооны дагуу нөхөн хангахад цэргийн дайчлгаа, цэрэг татлагын ажлыг Улаанбаатар хотын хэмжээнд зохион байгуулж, олон мянган залуучуудыг эх орноо батлан хамгаалах үйлсэд илгээж байлаа.

1939 оны Халхын голын болон 1945 оны Чөлөөлөх дайн, 1947-1948 оны Баруун хилийн тулгаралтад оролцож, МАХЦ-ийн нэгтгэл, ангиудад удирдах албан тушаалд томилогдон, байлдааны үүрэг, даалгаврыг амжилттай гүйцэтгэж, эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлын төлөө эрэлхгээр тулалдаж явсан, хожмоо Улаанбаатар хотын Цэргийн хэлтсийн дарга болон удирдах албан тушаалд ажиллаж байсан хошууч генерал Р.Осор, хурандаа М.Сияанямбуу, хурандаа

тогтвор суурьшилтай ажиллаж тус бүр 10 гаруй жилийн түүхийг бичилцжээ.

Түүхт 95 жилийн хугацаанд Нийслэлийн Цэргийн хэлтэст ажиллаж байсан дарга, офицеруудаас Р.Осор 1944 онд Монголын анхны 11 генералын нэг нь болж хошууч генерал, Цэргийн штабын орлогчоор ажиллаж байсан хурандаа Ж.Бадамбаазар 2011 онд бригадын генерал, 2017 онд хошууч генерал цол хүртсэн бөгөөд хурандаа цолыг 30 гаруй офицер хүртсэн байна.

Нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ажиллагсдын дунд олон улсын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн 20 гаруй офицер, ахлагч одоо ажиллаж байна.

Нийслэл, дүүргийн Цэргийн штабууд нь Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Зэвсэгт



Өвөр эгнээнд, зүүн гар талаас: Хурандаа Т.МӨНХБАЯР, хурандаа Ж.БОЛДБААТАР, хурандаа Ц.АНХБАЯР  
Арын эгнээнд, зүүн гар талаас: Ахмад Ц.ЭНХТАЙВАН, дэд хурандаа С.БАЯРМАГНАЙ, хошууч Б.ЧИМЭД, ахлагч Д.ГАНЗОРИГ

Ц.Долгорсүрэн, Н.Сүхбаатар, Э.Халтар, дэд хурандаа Ж.Чимэд, Ж.Тойнхүү, ахмад Х.Хажид, ахмад Д.Сэмжид, А.Дамдин, ахлах дэслэгч Н.Батаа, Ч.Дашням нарыг бид өнөөдөр бахархан хүндэтгэж байна.

Нийслэлийн Цэргийн штаб /хэлтэс/-ын 95 жилийн түүхэн хугацаанд давхардсан тоогоор цэргийн өндөр боловсрол, мэдлэг, дадлагатай, шилдэг тэргүүний 30 гаруй хүн удирдаж байснаас Жүрмэдийн Ёндон /1929-1930, 1939-1941 он/, Баяндүүрэнгийн

хүчний үйл ажиллагааг сурталчлах, дайчилгааны болон цэргийн бэлтгэл үүрэгтний сургалт, дадлага, цэргийн бүртгэл, цэрэг халалт, татлагын ажлыг зохион байгуулах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, хугацаат цэргийн алба хаагчид болон тэдний ар гэрт дэмжлэг, тусалцаа үзүүлэхэд өдөр тутмын ажлаа чиглүүлэн, Улаанбаатар хотынхоо ирээдүйн төлөө сэтгэл, зүтгэлээ дайчлан ажиллаж байна.

## ЦЭРГИЙН ШТАБЫНХАН ЯМАР Ч ҮЕД ҮҮРГЭЭ НЭР ТӨРТЭЙ БИЕЛҮҮЛСЭЭР ИРСЭН



ирээдүйтэй офицер, ахлагч нар цэл залуугаараа тэтгэвэрт гарч байлаа.

1993 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн хэлтсийг татан буулгаж, ажил хариуцсан гурван мэргэжилтэнг Төрийн захиргааны хэлтэст үлдээсэн нь орон нутагт батлан хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхэд ихээхэн бэрхшээл учирсан юм. Энэ бүтцээр орон нутагт ажиллаж байсан, тухайн ажлын мэдлэг, арвин туршлагатай, орон нутгийн онцлогоо мэддэг, нэр хүндтэй тэргүүний олон офицер халагдсан юм. Энэ үед гадаадад зорчих, амьдрах газраа өөрөө сонгох зэрэг нь чөлөөтэй болсноор иргэдийн шилжилт хөдөлгөөн эмх замбараагүй болж, цэргийн тоо бүртгэл завсардах, цэрэг татлагаас зайлсхийх явдал газар авч байлаа. Энэхүү бүтэц 1999 оныг хүртэл үргэлжилсэн юм. Бид үндсэн зэрэгт ажлаа гүйцэтгэхийн зэрэгцээ нийслэлийн иргэд, байгууллагын аюулгүй байдал, хэвийн ажиллаж амьдрах боломжийг хангах үүргийг хүлээж байлаа.

Шилжилтийн буюу улс орны маань эдийн засгийн чадавч, сахилга, хариуцлага бүхэлдээ суларсан тэр хүнд үед үйлдвэрлэлийн осол, цахилгаан, дулааны саатал, түүнээс үүссэн хөлдөлт ихээхэн гарч байсан. Үүнээс урьдчилан сэргийлэх, богино хугацаанд сэргээх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөөц бололцоогоо дайчлан ажилласны хүчинд хохирол багатай даван туулж чадсан юм. Тэр үед нийслэл, дүүргийн Цэргийн штаб нь онцгой комиссын ажлын "аппарат" байхаар хуульчлагдсан байсан юм. Өвөл зам, талбайд үүссэн халтиргаа гулгаа, нийслэлд гарсан хүн, малын гоц халдварт өвчин, ой хээрийн түймэр унтраах, үер, шар усны аюулаас иргэд, байгууллагыг авран хамгаалах ажлыг Цэргийн штаб нийслэлийн цэрэг, цагдаагийн байгууллагуудтай хамтран гардан зохион байгуулж байлаа. Улсын хэмжээнд өвөлжилтийн байдал хүндэрч олон аймаг, сум зурад нэрвэгдсэн үед хөдөөгийн малчдад тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулан нийслэлийн иргэдийн итгэл сэтгэл шингэсэн тусламжийн барааг Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Төв аймгуудад хүргэж байв.

Дээрх ажлуудыг Нийслэл, дүүргийн удирдлага, тамгын газрын ажилдаа үнэнч, мэргэшсэн, тогтвор суурьшилтай ажиллаж байсан ажилтнууд, Цэргийн штабын албандаа үнэнч, сэтгэл зүй, бие бялдрын өндөр бэлтгэлтэй чадварлаг бие бүрэлдэхүүн баяр, амралтын өдрүүдэд ч 24 цагаар үүрэг гүйцэтгэн нэр төртэй биелүүлж байсныг баярын энэ өдөр дурсахад таатай байна.

Нийслэлийн Цэргийн штабын 95 жилийн ойн баярыг тохиолдуулан нийслэл, дүүргийн удирдлага, цэргийн хэлтэс, штабуудад ажиллаж байгаа хамт олон болон гавьяаныхаа амралтыг эдлэн суугаа ахмадууддаа эрүүл энх байж, эх орноо батлан хамгаалах ариун үйлс нь үргэлж галын дел мэт өөдөө дэвжин дээшилж байхын ерөөл өргөө.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орлогч асан, чөлөөнд байгаа хурандаа Г.ЯНЖИВ

# ЦЭРГИЙН ШТАБ

# 95

ж/ил



## БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1980 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар зарлигаар Улаанбаатар хотын Багануур район байгуулагдсан. Батлан хамгаалахын сайдын тушаалаар 1986 оны 2 дугаар сард Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтэс нэртэйгээр анх байгуулагдаж, 1993 оноос Цэрэг-иргэний хамгаалалтын штаб, 2004 оноос Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд даргаар нь дэд хурандаа С.Дашдорж, хошууч Л.Батцэнгэл, дэд хурандаа А.Аанай, дэд хурандаа П.Пүрэв, хурандаа Ц.Энхбат, хурандаа Н.Дүгэрсүрэн, хурандаа Ж.Энхбат нар ажиллаж байв. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Аймаг, нийслэл, дүүргийн Цэргийн штабын дүрэм"-ийн дагуу



Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Одоо Цэргийн штабын даргаар хурандаа З.Майдар, төлөвлөлт, сургалтын офицероор дэд хурандаа М.Мөнгөтулга, тоо бүртгэлийн офицероор дэд хурандаа Д.Баасанхүү, мэдээллийн аюулгүй байдлын офицероор ахмад Ч.Жаргалсайхан нар ажиллаж байна.



## БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ



Улаанбаатар хотыг 1965 онд районы зохион байгуулалтад шилжүүлэхэд Октябрийн районы Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны бүтцэд Цэргийн төлөөлөгч, Иргэний хамгаалалтын штабын дарга гэсэн орон тоо батлагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Улмаар 1965-1975 онд Октябрийн районы

АДХГЗ-ны Цэргийн төлөөлөгч, 1975-1979 онд Цэрэг-иргэний хамгаалалтын тасаг, 1979-1983 онд Цэргийн хэлтэс, 1983-1992 онд Цэрэг-иргэний хамгаалалтын штаб, 1992-2003 онд Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтэс, 2003-2005 онд Цэргийн болон гамшгаас хамгаалах штаб, 2005 оноос Цэргийн штаб нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд Цэргийн төлөөлөгчөөр ахмад Ц.Ядамсүрэн, Цэргийн хэлтсийн даргаар хурандаа Ж.Самбуу, Иргэний хамгаалалтын штабын даргаар бага дэслэгч С.Энэбиш, хошууч Н.Лхазай, Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтсийн даргаар дэд хурандаа Н.Энхтайван, хурандаа Ж.Мягмаржав, Цэргийн штабын даргаар хурандаа Ж.Намнансүрэн, хурандаа Л.Ганбаатар, хурандаа Ч.Батхүрэл нар ажиллаж байв. Одоо Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргаар хурандаа Л.Мөнхбат, төлөвлөлт, сургалтын офицероор дэд хурандаа Д.Эрдэнэбаяр, дайчилгааны офицероор дэд хурандаа С.Бүдрэгчаа, тоо бүртгэлийн офицероор хошууч Б.Батболд, мэдээллийн аюулгүй байдлын офицероор ахлах дэслэгч Б.Дэлгэрмаа, шуурхай байдлын ахлагчаар ахлах ахлагч Б.Дэмбэрэлбалжинням нар ажиллаж байна.



## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ

Багахангай хорооны Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны бүтцэд Цэрэг-иргэний хамгаалалтын штабыг бий болгосноор Тамгын газрын дарга Б.Ганболд штабын төлөөлөгчийн албан тушаалыг 1989-1990 онд давхар хариуцаж байв.



Улсын Их Хурлын 1992 оны 18 дугаар тогтоолоор Багахангай хороог татан буулгаж Багахангай дүүрэг болгожээ. Энэ хугацаанд Цэрэг-иргэний хамгаалалтын штабын даргаар ахмад А.Баттулга, Цэргийн төлөөлөгчөөр дэд хурандаа М.Болд, дэд хурандаа В.Самбуу, Цэргийн штабын даргаар дэд хурандаа Н.Маньбазар, Л.Жаргал, Ц.Батбаатар, хурандаа

Л.Баатарзоригт, Ж.Баатарзориг, Г.Лхагвасүрэн нар ажиллаж байв. Одоо Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргаар хурандаа Б.Батмөнх, тоо бүртгэл, нөхөн хангалтын офицероор ахмад Б.Отгонжаргал нар ажиллаж байна.



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ



Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн дагуу УИХ-ын 1992 оны 18 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийг байгуулжээ. Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах Ерөнхий газар, Цэргийн төв эмнэлэг, Зэвсэгт хүчний 13, Хилийн хоёр, Онцгой байдлын хоёр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэхийн дөрвөн анги, байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг цэргийн тодотголтой дүүрэг юм. Цэргийн штаб нь район, дүүргийн бүтэц, зохион байгуулалтад Цэргийн төлөөлөгч,

Цэргийн тасаг, Иргэний хамгаалалтын штаб, Цэргийн хэлтэс, Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтэс, Цэргийн штаб зэрэг нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, тухайн он жилүүдэд Цэргийн төлөөлөгч, тасаг, хэлтэс, штабын даргаар хошууч Ч.Анард, ахмад Б.Дэмчигжав, хошууч Ч.Лхаажав, хурандаа Л.Цэвэгдорж, дэд хурандаа Б.Давгийхорлоо, С.Цэвэл, хурандаа Л.Раднаасэд, Ч.Цог нар томилогдон ажиллаж байжээ.

Одоо Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргаар дэд хурандаа Т.Амартогтох, дайчилгааны офицероор дэд хурандаа Ш.Бат-Өлзий, тоо бүртгэлийн офицероор дэд хурандаа Э.Амарбат, мэдээллийн аюулгүй байдлын офицероор дэд хурандаа Б.Уранчимэг, төлөвлөлт, сургалтын офицероор хошууч Л.Батзориг, шуурхай байдлын ахлагчаар ахлагч О.Дэлгэрдалай ажиллаж байна.



## НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 88 дугаар зарлигаар Нийслэлийн Налайх хотыг зохион байгуулахад анхны Цэргийн төлөөлөгчийн орон тоог бий болгожээ. Налайх хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны Цэргийн төлөөлөгч, Цэргийн тасаг, Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтэс, Цэрэг-иргэний хамгаалалтын штаб, Цэргийн бөгөөд гамшгаас хамгаалах штаб, Цэргийн штаб болон өргөжиж, тухайн үед даргаар нь ахлах дэслэгч Б.Баатар, ахмад Х.Хажид, бага дэслэгч Н.Батаа, ахлах дэслэгч Д.Төрхүү, ахмад Н.Зандраасүрэн, ахмад Н.Арслан, хошууч Л.Санжмятав, дэд хурандаа Д.Пүрэв, дэд хурандаа Ц.Зунай, хурандаа Ж.Сүрэнжав, Б.Лхагвасүрэн, Д.Байгал, В.Батболд нар ажиллаж, байв.



Одоо Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргаар хурандаа Н.Энхбат, тоо бүртгэлийн офицероор дэд хурандаа Г.Гантөгс, төлөвлөлт, сургалтын офицероор хошууч Л.Ганхуяг, мэдээллийн аюулгүй байдлын офицероор ахмад О.Батсүрэн нар ажиллаж байна.



## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ



БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 79 дүгээр зарлигаар Улаанбаатар хотыг дөрвөн районд хуваасан бөгөөд Сэлбэ голлоосбаруун тийш хэсгийг Сүхбаатарын район хэмээн нэрлэжээ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтөөр тус дүүргийг 1992 онд Сүхбаатар, Чингэлтэй гэсэн хоёр дүүрэгт

хуваан шинээр зохион байгуулсан түүхтэй. Энэ хугацаанд Цэргийн штаб нь район, дүүргийн бүтэц, зохион байгуулалтад Цэргийн төлөөлөгч, Цэргийн тасаг, Иргэний хамгаалалтын штаб, Цэргийн хэлтэс, Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтэс, Цэргийн штаб нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, тухайн он жилүүдэд цэргийн төлөөлөгч, тасаг, хэлтэс, штабын даргаар хошууч Ш.Ширчин, ахмад Т.Дорж, хурандаа Ц.Батхүү, дэд хурандаа Ч.Лхаажав, дэд хурандаа Н.Өлзий, хошууч Ж.Сундуй, дэд хурандаа Г.Агваансовд, Б.Суурьсүрэн, Ж.Сүрэнхордорж, Д.Содном, хурандаа Ж.Болдбаатар, Б.Готовдорж, Л.Батаа нар томилогдон ажиллаж байжээ. Одоо Цэргийн штабын даргаар хурандаа Ц.Бямбасүрэн, тоо бүртгэлийн офицероор дэд хурандаа Б.Баянмөнх, дайчилгааны офицероор дэд хурандаа Х.Бат-Амгалан, төлөвлөлт, сургалтын офицероор хошууч И.Нямсүрэн, мэдээллийн аюулгүй байдлын офицероор ахмад Э.Батсүрэн, шуурхай байдлын ахлагчаар ахлах ахлагч Э.Төмөрчулуун нар ажиллаж байна.



## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ

Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн "Улаанбаатар /нийслэл/ хотын район, хороог татан буулгаж шинээр дүүрэг байгуулах тухай" 18 дугаар тогтоолоор Октябрийн районыг татан буулгаж, Баянгол болон Сонгинохайрхан дүүргүүдийг шинээр байгуулсан.




Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн "Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг тогтоох тухай" 25 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтэс байгуулагдсан түүхтэй. 1992-1993 онд Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтсийн анхны даргаар хошууч Б.Маяахүү, 1992-2007 онд Цэрэг-иргэний хамгаалалтын штабын даргаар хурандаа Р.Нэргүй, 2007-2016 онд

Цэргийн штабын даргаар хурандаа А.Баттулга нар ажиллаж байв. Одоо Цэргийн штабын даргаар дэд хурандаа Г.Ялалт, тоо бүртгэлийн офицероор дэд хурандаа Б.Нямгэрэл, дайчилгааны офицероор хошууч Д.Ариунболд, мэдээллийн аюулгүй байдлын офицероор ахмад Ч.Отгонсүрэн, төлөвлөлт, сургалтын офицероор дэслэгч Б.Батцэцэг, шуурхай байдлын ахлагчаар ахлагч Д.Нацаг нар ажиллаж байна.



## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн дагуу УИХ-ын 1992 оны 18 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийг байгуулжээ. Цэргийн штабын анхны төлөөлөгчөөр ахмад Л.Цэвэлдорж, Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтсийн даргаар дэслэгч Ц.Пүрэвжав, хошууч М.Сүхээ, ахмад Б.Мягмаржав, хошууч Ч.Цэрэндорж, дэд хурандаа Ш.Ширчин, Д.Даваа, Д.Чинбат, хурандаа Г.Янжив, хошууч Ч.Цог, дэд хурандаа Д.Мөнхбат, Цэргийн штабын даргаар хурандаа Ч.Батхүрэл, А.Баттулга нар ажиллаж байв. Одоо Цэргийн штабын төлөвлөлт, сургалтын офицероор дэд хурандаа Г.Жаргалсайхан, тоо бүртгэлийн офицероор ахмад Н.Насанбат, мэдээллийн аюулгүй байдлын офицероор ахмад Н.Цэцэгбал, дайчилгааны офицероор дэслэгч Ц.Чингүүнболд, шуурхай байдлын ахлагчаар ахлах ахлагч М.Төрмандах нар ажиллаж байна.



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБ

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн дагуу УИХ-ын 1992 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Чингэлтэй дүүргийг шинээр зохион байгуулах шийдвэр гарч, их хотын хойморт залрах Чингэлтэй хайрхан уулаараа овоглосон нэгэн шинэ дүүрэг мэндэлсэн юм. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэрэг-иргэний хамгаалалтын хэлтсийн даргаар дэд хурандаа Л.Батболд, хурандаа А.Дамцагдорж, Цэргийн штабын даргаар дэд хурандаа Т.Эрдэнэсүх, хурандаа Ж.Мягмаржав нар ажиллаж байв. Одоо Цэргийн штабын даргаар хурандаа Ж.Даваарагчаа, тоо бүртгэлийн офицероор дэд хурандаа Н.Сүхбаатар, дайчилгааны офицероор дэд хурандаа О.Мөнхжаргал, төлөвлөлт, сургалтын офицероор ахмад Н.Лхамжав, мэдээллийн аюулгүй байдлын офицероор ахмад Д.Оюунчимэг, шуурхай байдлын ахлагчаар ахлах ахлагч С.Цэндээсэм нар ажиллаж байна.



## ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ 75 ЖИЛИЙН ОЙД

**БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хошууч Т.СҮХБААТАР**

Нэгэн цагт дэлхийн түүхийг бичиж явсан монголчууд өвөр зуураа эрх мэдэл, албан тушаал, эд хөрөнгө, эмс хүүхний төлөө тэмцэлдэн бие биеэ алж устган гаднын улс орны эрхшээлд орж тусгаар тогтнолоо алдсан гашуун түүхийн эхлэлийг тавьсан.

Өвөр Монгол 1636 онд Манжид эзлэгдэн дагаар орж улмаар 1691 онд Халх Монгол Манж Чин гүрний вассал болж,

гэсэн л ойлголттой байсан юм. Хамгийн гол нь хоёр хөрш маань Монголын талаар аль хэдийнээ урьдчилан тохиролцсон байжээ. 1912 оны Монгол Оросын гэрээгээр хаант Оросын тал Монгол улсын өөртөө эзэрхэг ёс (автономит)-ыг (статус кво, де-факто болон де-юре) хүлээн зөвшөөрч, Монголын нутагт хятад цэрэг оруулахгүй байх, монголчууд өөрсдөө цэрэг байгуулахад Хаант Орос улс туслахаар болсон. Харин Оросын худалдаачид Монголын нутагт чөлөөтэй худалдаа хийх

Монголын дотоод хэрэгт Хятад, Орос 2 оролцохгүй байхаар тогтсон төдийгүй эзэн хаан, Засгийн газар, нутаг дэвсгэр, хил хязгаар, цэрэг зэргийг хэвээр байлгах болжээ. Мөн Хятад иргэдийг олноор суурьшуулахгүй байх, Орос, Хятадын цэргийг оруулахгүй байх, олон улстай худалдаа, үйлдвэрийн хэргээр харилцах бүрэн эрхтэй байв. Энэ бүхнээс үзвэл Монгол Улс нь үнэн хэрэгтээ бие даасан улсын шинжтэй оршин тогтнож байсан гэж үзэж болохоор эгээ.

Хаант Орос улс үгүй болж,

өөрсдийгөө тусгаар улс гэж үзэж байсан ч Зөвлөлт Орос улс, ДИУ хоёр хувь заяаны асуудлыг нь нэгэнт тохиролцсон байсан юм.

Зөвлөлт Орос улсын Гадаад хэргийн сайд Лев Карахан, ДИУ-ын Гадаад хэргийн сайд Вэллтон Ку нарын 1924 оны 5 дугаар сарын 31-ний өдөр үзэглэсэн албан баримтад "... гадаад Монголыг Хятадын салшгүй нэг хэсэг гэдгийг ЗХУ хүлээн зөвшөөрч байна. Иймээс Хятадын дотоод асуудал буюу Суверенитетийг хүндэтгэн үзэх болно ..." гэжээ. Энэ гэрээг ЗХУ-

халдан довтолсон тохиолдолд бие биедээ дэмжлэг тусламж үзүүлэх тухай аман хэлэлцээр байгуулж авчээ. Улмаар Алс Дорнодод байдал түгшүүртэй болсон үед уг аман хэлэлцээрийг улс төрийн албан ёсны баримт бичиг болгон Монгол, Зөвлөлтийн харилцан туслалцах тэмдэглэл бичиг (протокол) хэмээх нэрийн дор үзэглэжээ.

Гэтэл Монгол, Зөвлөлтийн тэмдэглэл бичигтэй холбогдуулан 1936 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр Хятадын Засгийн газраас ЗХУ-ын Засгийн

# ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨХ ХАГАС ЗУУН ЖИЛИЙН ТЭМЦЭЛ

Зүүнгарын хаант улс 1755 онд эзлэгдэж, өвөг дээдсийнхээ олон зуун жилийн халуун амь бүлээн цусаар бий болгосон тусгаар тогтнолоо алдсан юм.

Монголчууд тусгаар тогтнолоо алдахад нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг нь үндэсний эв нэгдэл яах аргагүй мөн. Халх, Ойрад, Ар, Өвөр Монгол гэх зэргээр талцан тэмцэлдэж дор бүрнээ өөрийн гэсэн улс байгуулан эрх мэдэлд хүрэх гэж шуналтан зүтгэсэн нь ийм харамсалтай байдлаар хүргэсэн билээ. Гэвч тусгаар тогтнолоо эргүүлэн авах Галдан бошигт хаан, Амарсанаа, Чингүнжав нарын бослого хоорондын эв нэгдэлгүй байдлаас болж амжилт олоогүй юм.

Монголчууд бид XVII-XX зууны эхэн хүртэл Манж Чин гүрний хамгийн алслагдмал, харанхуй бүдүүлэг хөгжлийн гадна үлдсэн бүс нутаг болж төрөл бүрийн алба барьж, шаардлагатай үед цэрэг, зэвсгийн хүчээр туслах үүрэг хүлээж байсан. Энэ ч үүргээ биелүүлж ирсэн. Гэвч XIX зууны хоёрдугаар хагас XX зууны эхэнд Чин улсын дотоод, гадаад байдал ихээхэн сулран доройтож өөрийн улсаа ч хянах чадваргүй болж ирсэн байдаг. Манж Чин гүрний толгойд Хятад бодлого улам бүр баттай сууж Монголыг үгүй хийх "Шинэ засгийн бодлого" гэчийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Монголын хувьд энэхүү бодлого нь түүний вассалын статусыг эвдэж, Хятадын нэгэн муж болгох зорилготой байлаа. Тухайлбал, үүнийгээ хэрэгжүүлэхээр хятадууд монгол нутагт суурьших, монгол, хятад хүмүүс ураг барилдах, монгол хүн хятад нэр хэрэглэх зэргийг хориглосон Манжийн хуулийг хүчингүй болгож, хятад иргэдийг олноор нь монгол нутагт нүүлгэн шилжүүлж тариалан эрхлүүлэх, ашигт малтмал бүхий газрыг олж уурхай нээх зэрэг арга хэмжээ авч эхэлжээ. Ийнхүү монгол үндэстний язгуур эрх ашиг хөндөгдсөн явдал Монголд эрх чөлөөний хөдөлгөөн газар сайгүй өрнөхөд хүргэжээ. Харин түүнийг зарим ноёд, лам нар удирдан зохион байгуулж, тусгаар тогтносон төр улсаа сэргээн байгуулах үйлсийг сэдсэн билээ. Энэ нь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалд хүргэсэн юм.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд монголчууд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан ч дэлхийн улс орнууд тэр дундаа хоёр хөрш нь хүлээн зөвшөөрөөгүй юм. Бид өөрөө өөрсдөдөө тусгаар тогтнол олгоод байсан билээ. Дэлхий дээр нэг ч улс Монголыг тусгаар улс гэж үзсэнгүй. VIII Богдын тэргүүлсэн засаг дэлхийн улс орнуудаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх олон алхам хийж байсны нэг нь тухайн үеийн өндөр хөгжилтэй өрнөдийн улс орнууд болох Британийн эзэнт гүрэн, АНУ, Франц, Япон, Герман гэх мэтийн улс байжээ. Гэсэн ч дэлхийн нэгдүгээр дайн ид эхэлж улс орнууд Монголын тусгаар тогтнолыг анзаарах ч сөхөөгүй зөвхөн Чин гүрний нэг хэсэг

эрхтэй болж, монголчууд өөр гадаад улстай гэрээ байгуулахад урьдаар заавал Хаант Орос улстай хэлэлцэж байхаар тогтоожээ. Монголчууд тухайн үедээ автономит гэдгийг бүрэн тусгаар тогтнолын хэмжээнд л ойлгож байжээ. Гэвч энэ бол муу дотроо хамгийн сайн боломжит хувилбар байсан гэж үзэж болно. Хаант Орос анх удаа Монголыг бие даан гэрээ байгуулах эрхтэй эрх зүйн субъект хэмээн үзсэнд гол үндэс оршиж байгаа юм. Энэ гэрээнд мэдээж хэрэг хятадууд дуртай байгаагүй нь ойлгомжтой. Өөрсдийнх нь нэг муж гэж үзэж байсан Монголын асуудлыг дотоод хэрэгт нь оролцож шийдсэнд ихэд дургүй, тааламжгүй хүлээн авчээ.

Бээжинд 1912 оны 12 дугаар сард Хаант Орос, Дундад Иргэн Улсын (ДИУ) хэлэлцээр эхэлжээ. ДИУ Монгол дахь Оросын худалдаа, эдийн засгийн онц эрхийг хөндөхгүй байхаа амлаж, Монгол-Оросын 1912 оны гэрээг хүчингүй болгох шаардлага тавьж байв.

Хаант Оросын тал 1912 оны Монгол-Оросын гэрээг ДИУ хүлээн зөвшөөрч, Монголын автономит эрхийг хүндэтгэж, Монгол дахь ДИУ-ын эзэн эрхийг монголчуудаар хүлээн зөвшөөрүүлэхэд тусална гэсэн аюултай шаардлага тавьжээ. Хэлэлцэгч талууд удаан маргалдсаны эцэст 1913 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр тунхаглах бичгийг байгуулсан. Тунхаг бичгийн гол агуулга нь Хаант Орос улс нь ДИУ-ын Монголыг хэмжээтэй захирах эрхийг зөвшөөрсөн, Монголын автономит эрхийг ДИУ зөвшөөрөх, ДИУ Монголын дотоод хэрэгт оролцохгүй байх, Хаант Орос улс Монголд консулыг хамгаалах цэргээс өөр цэрэг суулгахгүй байх, Гадаад Монголын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, Монгол-Оросын 1912 онд байгуулсан гэрээг ДИУ хүлээн зөвшөөрөх гэх зүйлүүд байжээ.

Богд хааны Засгийн газар дээрх тунхаг бичгийг эсэргүүцэн Хүрэн дэх Оросын консулын газарт нот бичиг илгээж байсан авч талаар болсон юм. Ийнхүү хэдийгээр автономит эрхтэй ч Хятадын нэг хэсэг хэвээр болно хэмээн хоёр хөрш маань тохиролцож 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд үгүй хийсэн билээ. Гэсэн ч монголчууд тусгаар тогтнох замаа эрэлхийлсээр л байжээ. Үүний нэг жишээ нь 1915 оны Хиагтын гурван улсын гэрээ юм. Уг хурлаар талууд өөр өөрсдийн ашиг сонирхлын үүднээс томоохон зорилго өвөртлөн очсон ч 1913 оны Бээжингийн хурлын үр дүнтэй адилхан ялгаагүй зүйл болжээ.

Гурван улсын гэрээгээр Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан байдлыг хязгаарлаж, "Өөртөө эзэрхэх Гадаад Монгол"-ын хилийг зөвхөн Халх дөрвөн аймаг, Ховдын хязгаараар зааглаж, монголчууд нэгдмэл нэг улс болох үйл хэргийг хүчээр тасалжээ. Ингэснээр Ар, Өвөр зэрэг монголчууд саланги тусгаар оршиход хүрчээ.

Гол ахицтай зүйл нь

1917 онд Октябрын хувьсгалын үр дүнд Орос улс иргэний дайнд нэрвэгдэн Монголын талаарх бодлогыг үндсэндээ хаясан энэ цаг үеийг ДИУ чадмаг ашиглан Оросын нөлөөг таягдан хаяж өөрсдийн нөлөөг тогтоохоор шийдсэн юм. Нөгөө талаар Орос улсад Зөвлөлт засаг нэгэнт тогтох нь тодорхой болж Хиагтын гэрээний нэгэн субъект болох Хаант Орос үгүй болж гэрээг хүчин төгөлдөр бус хэмээн Бээжин үзэх болжээ. Мөн улаан Оросын аюулыг тэлэхээс урьтаж Монголыг ямар нэгэн аргаар өөрийн бүрэн нөлөөнд оруулах нь Бээжинд зайлшгүй хийгдэх гол ажлуудын нэг болсон юм.

Ингээд 1919 оны 10 дугаар сард Хятадын анфу бүлгийн гишүүн генерал Сю Шүжан 10 мянга орчим цэрэг дагуулан Монголд орж ирэн Монголын засгийн эрх баригчдыг сүрдүүлж автономитыг устгах бичигт гарын үсэг зуруулан 1919 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Хятадын Ерөнхийлөгчийн зарлигаар Гадаад Монголын автономит эрхийг цуцалсан байна. Энэ бол Мин улсын цэргээс хойш XX зуунд Монголд орж ирсэн Хятадын анхны цэргүүд байсан юм. Ийнхүү монголчууд сул дорой байдал, зарим нэгэн шахалтаар автономит эрхээ алдаж ямар ч статусгүй болж Хятадын нэг муж болсон юм.

1921 оны 2 дугаар сард Хаант Оросын генерал Барон Унгерн Зөвлөлт Орос улс руу өмнө талаас нь довтолхын тулд Монголд нэвтрэн Нийслэл хүрээг Хятадын цэргээс чөлөөлж VIII Богдыг хаан ширээнд нь буцаан залж, Монголын Засгийн газрыг дахин эмхлэн байгуулсан байна. Энэ нь дахин тусгаар тогтнолын хэмжээний үйл явдал болжээ. Гэсэн хэдий ч энэ Засгийн газар хэдхэн сарын настай байжээ. Зөвлөлт Орос улсын тусламжтайгаар Монголын шинэ цагийн төлөөлөл хувьсгал хийж 7 дугаар сард Хүрээг эзлэн тусгаар тогтнолоо зарласан юм. Үндсэн хуультай өөрийн гэсэн засгийн газартай мөн цэрэг, захиргаа, хил хязгаартай шинэ улс хэмээн тунхаглан зарлажээ. Хэдий


Харин 1924 оны дээрх гэрээнд Зөвлөлтийн талаас гарын үсэг зурсан Н.Карахан Хятадын "Ишибао" хэмээх сонин сурвалжлагчтай ярилцахдаа "Монголд өөрийн засаглал тогтоох эрх олгох нь Монгол, Хятадын харилцааны асуудлыг бүх талаар үндсэнд нь шийдвэрлэх зөв арга болно" гэж тэмдэглэж байна. Харин 1924 оны 6 дугаар сарын 25-ны өдөр "Ардын эрх" сонинд "Орос, Хятад хоёр улсын гэрээ тогтоосон тухай" өгүүлэл хэвлэгдэн гарч "Монголын ард түмэн дундад улсын харгис засгийн дахин дарлан бурангуйлахыг тэсвэрлэхгүй ..., хэзээд эсэргүүцэн тэмцэх болно" гэсэн утгатай зүйлс бичигдсэн байна.

Зөвлөлтийн гадаад харилцаа эрхэлсэн ардын комиссар Г.И.Чечерин 1924 оны эцсээр "Монгол Улс Хятад улсын нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Үүний хамт, Монголын автономит байдал нь тусгаар улсын хэмжээнд хүрч өөрийн дотоод асуудлыг Хятадаас тусдаа шийдэх төдийгүй гадаад харилцааны салбарт ч өөрийн бие даасан бодлого явуулах чадвартай байгааг ЗХУ харгалзан үзэж байна" гэж бөөрөнхий мэдэгдэл гаргасан байдаг.

Монголын эрх баригчдад энэ гэрээ нь таалагдаагүй бөгөөд нэлээд ширүүн эсэргүүцэж байсан юм. Үүнийгээ ЗХУ-ын Засгийн газар Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, өөрөөр хэлбэл Хятадаас Монгол улсыг довтолж эзлэх аюулыг сэрэмжилсэн улс хоорондын эрх зүйн чухал арга хэмжээ гэж Монгол Улсын эрх баригчдад тайвшруулан ойлгуулж байлаа.

Гэвч Зөвлөлтийн тал Коминтернээр дамжуулан хүчтэй даралт шахалт явуулсны дүнд Монголд улс төр, эдийн засгийн нөлөөгөө үлэмж бэхжүүлж, 1934 оны сүүлчээр худалдаа, санхүүгийн асуудлаар хэлэлцээр байгуулахаар Москвад очсон Монголын төлөөлөгчидтэй гаднын довтолгооны аюулыг урьдчилан зайлуулж сэргийлэх хэрэгт бүх талаар харилцан туслалцах, гуравдагч этгээд

газарт эл алхамыг эсэргүүцэж "Хятад, Зөвлөлт хоёрын хооронд 1924 оны 5 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан гэрээний 5 дугаар зүйлийн дагуу Гадаад Монгол нь Хятадын салшгүй хэсэг учраас түүнтэй гадаадын ямар нэгэн улс гэрээ байгуулж таарахгүй. Хятадын Засгийн газарт хүлээсэн үүргээсээ няцаж, Гадаад Монголтой дээрх протокол байгуулсан ЗСБНХУ-ын Засгийн газрын үйл ажиллагаа



нь Хятадын бүрэн эрхт байдал, 1924 оны Хятад, Зөвлөлтийн хэлэлцээрийн тогтоолыг зөрчиж буй нь эргэлзээгүй. Иймд миний бие эрхэмсэг танд хатуу эсэргүүцэл илэрхийлж, ЗСБНХУ-аас Гадаад Монголтой дээрх протокол байгуулсан нь хууль бус бөгөөд Хятадын Засгийн газар ямар ч нөхцөлд хүлээн зөвшөөрч чадахгүй" хэмээн мэдэгджээ.

Үүний хариуг Зөвлөлтийн Засгийн газраас нэг хоногийн дараа гаргаж, "Тэмдэглэл бичиг байгуулсан хийгээд түүний аль ч зүйл нь Хятадын бүрэн эрхт байдлыг хөндөөгүй бөгөөд Хятад болон БНМАУ-ын газар нутгийг санаархсан хэрэг огт бус бөлгөө. Эл тэмдэглэл бичгийг үзэглэснээр ЗХУ ба Хятад, ЗХУ ба БНМАУ-ын хооронд өдгөө хүртэл тогтсон харилцаанд ямарваа нэгэн өөрчлөлт орохгүй болой" хэмээн мэдэгдсэн ноот бичгийг Москвад суугаа Хятадын хэргийг түр хамаарагчид гардуулан өгчээ. Үүгээр ЗОУ Гадаад Монголыг Хятадын салшгүй нэг хэсэг гэдгийг 1924 онд баталсан шигээ дахин баталгаажуулсан байгаа юм.

БНМАУ-ын бүрэн эрхт байдлын тухай хоёрдмол агуулгатай байдал бий болсонд Монголын удирдагчид дургүйцэн өөрсдийн санаа бодлыг тодорхой илэрхийлж байлаа. Энэ нь эцэстээ Зөвлөлтийн улс төрийн бодлогыг сөрөн зогсож үгүйсгэсэн гэдэг хэргээр Монголын олон улс төрчид, эх орончдыг улс төрийн хилс хэргээр яллах үндэс болсон юм.

Монгол-Зөвлөлтийн 1936 оны харилцан туслалцах протокол бол Монголыг гэрээ байгуулах эрх зүйн субъект гэдгийг ахин баталгаажуулсан төдийгүй Зөвлөлтийн эрх ашиг энд бий шүү гэдгийг ахин батлан харуулсан хэрэг болжээ.

Энэ ч хүрээнд 1939 оны Халхын голын дайнд Монгол-Зөвлөлтийн хамтын хүч ялалт байгуулан Зөвлөлтийн нөлөө энэ бүс нутагт бий шүү гэдгийг батлан харуулж БНМАУ-ыг тусгаар улс болгох алхмыг дэлхий дахинд харуулж чадсан юм.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)



# ОРОСЫН АРМИЙН ЦОЛНЫ ТҮҮХ

Эртний Оросын армид цэргийн цол хэмээх зүйл байсангүй. Харин албан тушаал нь тухайн хүний үйл ажиллагаа, байр суурийн илэрхийлэл болж байв. Тухайлбал, аравт, зуут, мянгатын захирагч хэмээх албан тушаал нь одоогийн цолны үүргийг гүйцэтгэж байжээ. Ингээд та бүхэнд Оросын болон бусад армид цол хэрхэн бий болсон, ямар учир утгатай талаар мэдээллийг хүргэе.

## ТҮРҮҮЧ

Түрүүч (сержант) хэмээх үг нь франц хэлний алба хаагч (sergent) гэсэн үгнээс улбаатай. Анхны түрүүч цол нь XI зууны Англи улсад бий болсон байна. Гэхдээ тэр үед түрүүч цол нь цэргийн цол бус хааны өгсөнтөрөл бүрийн тушаалыг гүйцэтгэгчийг хэлдэг байжээ. Харин XII зууны үеэс Английн гудамжинд хэв журам мөрдүүлэгчид түрүүч цолыг хэрэглэж эхэлсэн бол XV зуунд Францын армид цэргийн цол хэлбэрээр хэрэглэж, удалгүй Герман, Английн армид нэвтэрсэн. Харин Хаант Оросын армид түрүүч цолыг 1716-1798 оны хооронд хэрэглэж байсан түүхтэй. ЗХУ-ын Улаан армид түрүүч цолыг 1940 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс хугацаат цэргийн алба хаагч нарт олгодог цол хэлбэрээр ашиглаж эхэлсэн байна. Орчин үед түрүүч цолны төгс хэлбэрийг АНУ-ын Зэвсэгт хүчин хэрэгжүүлж байна. 2010 онд хийсэн судалгаанаас харахад нийт цэргийн алба хаагчдын 40 орчим хувь нь түрүүч нараас бүрддэг ба ажил, мэргэжлийн онцлогийг нь илэрхийлсэн нарийн шатлал бүхий системтэй аж.

## АХЛАГЧ /ПРАПОРЩИК/

Оросын армид прапорщик хэмээх цолыг анх "Туг баригч" (знаменщик) хэмээн нэрлэж байгаад хожим буюу XVII зууны үеэс эртний славян хэлний "прапоръ" буюу "туг" гэж нэрлэн, хэвшжээ. Анхны ахлагч цолыг 1649 онд Алексея Михайлович хааны зарлигаар олгосон байна. Тухайн үедээ яг албан ёсны цэргийн цол гэхээсээ илүүтэй ёслол, хүндэтгэлийн хэлбэртэй байсан бол нэгдүгээр Петр хааны үед байнгын армийг хуульчилж баталсан үеэс цэргийн цол болжээ. Гэхдээ XVII-XX зууны үед прапорщик нь офицерын бүрэлдэхүүнд багтаж, тэр хэмжээний эрх мэдэл, үүрэг, тушаалыг биелүүлдэг байв. Учир нь Эзэн хааны цэргийн академид 12 настайгаасаа элсэн

орж зургаан жилийн хүнд, хэцүү сургалтын дараа олгогддог тул офицерын бүрэлдэхүүнд багтах аргагүй юм. Мөн дайн, байлдааны үед онцгой гавьяа байгуулсан байлдагч нь тусгай шалгалтыг өгч прапорщик болох

байдаг "хууль"-аар дундаж зууны үед Францын цэргийн тойргийн захирагчийг "капитан" буюу ахмад гэж нэрлэж байжээ. Хаант Оросын үед явган цэргийн ахмад цол нь орчин үеийн хошууч, гвардийн ахмад цол нь одоогийн



эрхтэй байсан нь энэхүү цолны нэр хүнд ямархуу түвшинд байсныг бүрэн илтгэнэ.

1912 онд хоёрдугаар Николай хаан цомхон Зэвсэгт хүчинтэй болохын тулд түргэвчилсэн буюу 8 сарын сургалт, бэлтгэлийн дараа прапорщик цолыг олгож эхэлжээ. Харин 1917-1972 оны хооронд ЗХУ-ын Улаан армид ахлагч цол огт ашиглаагүй юм.

## ДЭСЛЭГЧ

Дэслэгч буюу "Лейтенант" хэмээх үг нь франц хэлнээс гаралтай бөгөөд орлогч гэсэн утгатай. XV зууны эхэн үед Франц улсад захирагч, дарга нарыгаа орлон үлдэж буй хүнийг ингэж нэрлэдэг байж. Харин XVII зууны хоёрдугаар хагасаас цэргийн цол болсон байна. Хаант Оросын үед буюу 1701-1917 оны хооронд зөвхөн эзэн хааны флотод дэслэгч цолыг хэрэглэж байв.

Дэслэгч цолыг 1935 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс ЗХУ-ын Улаан армид офицерын анхны цол болгожээ. Тухайн үед цэргийн сургууль төгссөн сонгогчид болон энгийн сургуулийн цэргийн тэнхимийг төгсөгчдөд дэслэгч цол олгож байсан.

## АХМАД

Ахмад (капитан) нь латин хэлний "капут" буюу толгой гэсэн үгнээс үүсэлтэй. Мэдээж, цэргийн цолны гарал Франц улстай салшгүй холбоотой

хурандаа цолтой дүйцдэг байв. Учир нь ахмад цол нь ахлах офицер цолны ангилалд багтаж байсантай холбоотой аж. ЗХУ-ын Улаан армид ахмад цол нь одоогийн түвшиндээ хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд Усан флотын хувьд арай өөр хэлбэрээр одоо ч ашиглагдаж байна. Тухайлбал, флотын нэгдүгээр түвшний ахмад гэдэг нь хуурай замын цэргийн хурандаа цолтой дүйцдэг.

## ГЕНЕРАЛ БОЛОН МАРШАЛ

Генерал нь гол (главный), маршал нь төмрийн дарханы тах (кузнец подков) гэсэн франц үгнээс гаралтай цэргийн цол юм. 1917 оныг хүртэл Оросын цэргийн дээд цол нь генерал байсан бол 1935 оноос маршал болсон түүхтэй. Гэхдээ энэ хоёрын дээр бичигдэх нэг цол байдаг нь "Генералиссимус" юм. Энэхүү цолыг Оросын хамгийн анхны Цэргийн дүрэмд (1716 он) багтаасан ба нэгдүгээр Петр хаан Азивт хийсэн тулалдааных нь төлөө А.С.Шейнийг энэ цолоор шагнасан түүхтэй. Харин хамгийн сүүлийн генералиссимусийг ЗХУ-ын Дээд зөвлөлийн 1945 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор Иосиф Сталинд олгож байжээ. Маршал Рокоссовский цолыг нь гардуулах үеэр Сталинд "Маршал олон, харин генералиссимус ганцхан" гэж хэлж байсан гэдэг.

WWW.RUSSIA7.RU

## “НЭГ ХЯТАД” ЗАРЧМЫГ ...



АНУ-ын Тэнгисийн цэргийн хүчний мина тээвэрлэгч "McCampbell" хөлөг онгоц Тайванийн хоолойгоор гарсан байна. Энэ нь Энэтхэг-Номхон далайн бүс нутгийг чөлөөтэй, нээлттэй болгох АНУ-ын амлалт хэвээрээ гэдгийг харуулах зорилготой аж. АНУ-ын цэргийн хөлөг онгоц хамгийн сүүлд 1 дүгээр сарын дундуур Тайванийн хоолойгоор гарчээ. БНХАУ-ын эрх баригчид Тайвань бол улсынх нь салшгүй нэг хэсэг гэж бүс нутаг дахь Америкийн цэргийн аливаа оролцоог маш болгоомжлон хүлээж авдаг бөгөөд уг үйл явдалтай холбоотойгоор БНХАУ-ын Гадаад хэргийн яам "нэг Хятад" зарчмыг хүндэтгэхийг уриалжээ.

REUTERS


## БАЛЛИСТИК ПУУЖИН ХАРВАЖЭЭ



Хойд Солонгосоос Япон тэнгисийн чиглэлд ойрын зайн тусгалтай хоёр баллистик пуужин харважээ. Энэ тухай БНСУ-ын мэдээлснээр Вонсан хот орчмоос орон нутгийн цагаар 06.10 цагт харвасан баллистик пуужингууд нь 30 километрийн өндөрт хүрч, 230 километр хол ниссэн байна. Баллистик пуужин харвасантай холбогдуулан БНСУ-ын зүгээс хийсэн мэдэгдэлдээ "Шинэ коронавирусын тархалтын улмаас дэлхий дахин хүнд үеийг туулж байгаа энэ үед БНАСАУ зохисгүй үйлдэл гаргаж байна" хэмээгээд үүнийг нэн даруй зогсоохыг уриалсан байна. Харин Японы "NHK" телевиз мэдээлэхдээ, БНАСАУ-ын харвасан ойрын зайн тусгалтай хоёр баллистик пуужин нь Японы эдийн засгийн онцгой бүсэд хүрээгүй талаар дурджээ. Одоогоор пуужин харвасан тухай мэдээлэлд нарийн дүн шинжилгээ хийж байгааг Японы Батлан хамгаалахын сайд Таро Коно цохон тэмдэглэжээ.

CNN

## ЭВСЭЛД НЭГДЭВ



Умард Македон улс НАТО буюу Умард Атлантын гэрээний байгууллагын 30 дахь гишүүн болжээ. Энэ долоо хоногт тус улсын Төрийн далбааг НАТО-ийн Брюссель дахь төв байрны гадаа албан ёсоор мандуулах аж. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майкл Помпеогийн эвсэлд нэгдэж байгаад нь баяр хүргэж явуулсан захидалдаа "НАТО-д элсэн орж байгаа нь Умард Македоны Засгийн газар, иргэдийн олон жилийн хүчин чармайлтын үр дүн юм. Умард Македон НАТО-ийн гишүүн болсноор бүх бүс нутагт илүү нэгдэл, нягтралыг бий болгож, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангахад нэмэр болох юм. НАТО-ийн өндөр стандартад нийцэхийн тулд зайлшгүй хийх шинэчлэлийг явуулах хариуцлагыг хүлээж, гишүүнчлэлийн давуу талыг ашиглахыг хүсэж байгаа улс орон бүрд НАТО-ийн үүд хаалга нээлттэй" хэмээн дурджээ.

TACC

## ОХУ 500 ОРЧИМ ЗЭВСЭГЛЭЛ, ТЕХНИК ДЭЛГЭЖЭЭ



ОХУ-ын өндөр технологийн үйлдвэр "Ростех" корпорациас 57 мм-ийн "АУ-220М" хэмээх артиллерийн системийг БНЭУ-д зохиогдсон олон улсын зэвсгийн "DefExpo-2020" үзэсгэлэнгийн үеэр анх удаа танилцуулсан. Тус артиллерийн системийг

байлдааны машин, хуягт тээвэрлэгчид суурилуулан газар болон агаарын байг устгах боломжтой аж.

Мөн "Рубеж-Автоматика" компаниас зохион бүтээсэн дрон устгах зэвсгийг танилцуулсан юм. Тус төхөөрөмж нь ямар ч

операторын тусламжгүйгээр агаарт нисэж байгаа дроны хөдөлгөөнийг автоматаар илрүүлэх системтэй. ОХУ тус зэвсгийн үзэсгэлэнд ойролцоогоор 500 орчим зэвсэглэл, техник, бусад төхөөрөмжийг танилцуулсан байна. Энэ үеэр "Т-90С", "Т-90МС" танк, шинэчлэгдсэн "Т-72" танк, олон зориулалт бүхий байлдааны нисдэг тэрэг "Ми-171А2", "ТВ-7-117" хэмээх аварга хөдөлгүүртэй ачаа-тээврийн "Ил-114-300" онгоц зэрэг нь үзэсгэлэнд ирсэн үзэгчдийн анхаарлыг илүү татжээ. "Ростек" корпорацийн олон улсын харилцааны хэлтсийн дарга В.Кладов "Энэтхэг бол Орос улсын хамгийн гол зэвсэг худалдан авагч. Тийм учраас бид Энэтхэгийн цаг агаар, уур амьсгалд зохицсон техник, зэвсгүүдийг энд түлхүү танилцуулж байна" гэж онцолсон байна.

TACC

## "В-21" ОНГОЦНЫ ЗУРАГ ИЛ БОЛЛОО

АНУ-ын Агаарын цэргийн хүчин хамгийн сүүлийн үеийн стратегийн бөмбөгдөгч "В-21" онгоцныхоо зургийг олон нийтэд цацлаа. Тодруулбал, тус улсын Техас муж дахь "Диес" агаарын цэргийн баазад тус онгоц туршилтын нислэг үйлдэх үеэр зургийг нь авчээ. "В-21" онгоц нь стратегийн бөмбөгдөгч ангилал дотроо хамгийн сүүлийн үеийн гэж нэрлэгдэж байгаа

бөгөөд 2025 оноос үүрэг гүйцэтгэж эхлэх аж.

Одоогийн байдлаар онгоцны техникийн үзүүлэлтүүд нь тодорхой бус байгаа ч агаарын орон зайд илүү удаан нислэг үйлдэх, өндөр цэцтэйгээр байг устгах, радарт үл үзэгдэх зэрэг технологийн олон зүйл дээр нь шинэчлэл хийсэн байна.

ВВС



Нүүрийг бэлтгэсэн ахмад Э.ОЧХҮҮ

# Ц.Болормаа: ЦЭРГИЙН АНГИ Л МИНИЙ БАЙХ ЁСТОЙ ГАЗАР

Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд очиж үзээгүй, байрлаж үзээгүй офицер, ахлагч тун ховор. Хэрвээ та хэзээ нэгэн цагт тэнд очиж байсан бол Ц.Болормаа гэх бүсгүйн бэлтгэсэн хоолыг идэж байсан л гэсэн үг. Учир нь тэр бээр Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид 18 жилийг гал тогоонд өнгөрүүлсэн юм. Одоо Ц.Болормаа Зэвсэгт хүчний 011 дүгээр ангид номын санчаар ажиллаж байна. Ингээд түүнтэй хэсэг хөөрөлдсөнөө уншигч танаа болгооё.



**Сургалтын нэгдсэн төвтэй холбогдож байсан таны дурсамжаас ярилцлагаа эхэлье...**

-Миний хань Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид томилогдож, нөхрийгөө дагаад 1998 онд тус ангид ээлжийн тогооч, сав угаагчаар ажилд орж байлаа. Тухайн үед ангийн захирагчаар хошууч генерал Ч.Магсар ажиллаж байсан. Харин манай тасгийн даргаар ахлах тогооч А.Төмөртогоо ажиллаж байсан бөгөөд бид ч ажлыг үнэхээр "умалзуулдаг" байлаа шүү дээ. Энэ дашрамд, Тогоо эгчийгээ магтаад авъя гэж бодлоо. Тэр бол хамт олныг үнэхээр бүрдүүлж чаддаг, дайчин шаргуу зантай хүн. Би түүнээс хариуцлага, тэсвэр, тэвчээр гээд олон сайхан зан чанарыг сурсан.

**Та ажлыг "умалзуулдаг" байлаа гэсэн. Мэдээж ямар их ачаалалтай ажил вэ гэдгийг хэн хүнгүй мэднэ. Гэхдээ танаас энэ талаар сонсмоор байна...**

-Уг нь хөдөлмөрийн гэрээндээ 24 цаг ажиллаад 72 цаг амарна гэж заасан байдаг ч шаардлагатай үед хэдэн долоо хоногтой ч хонож ажиллах үе бишгүй их. Бүр дулааны улиралд гэрээсээ гарчхаад Тавантолгойгоос буухад хотын хүмүүс аль хэдийн өвлийн хувцсандаа шилжчихсэн байдаг. Ингэж л бид хонон өнжин ажил дээрээ байрлаж Зэвсэгт хүчнийхээ төлөө зүтгэдэг байлаа. Тухайлбал, цэргийн багуудын ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтын үеэр 100-1000 хүнд дөрвөн удаагийн халуун хоолоор үйлчилдэг. Маргаашийнхаа хоолыг бэлтгэхээр шөнөжин мах хэрчих, гурил зуурах нь энүүхэнд бөгөөд хоногт хоёр цагийн нойртой долоо хоног ажиллана. Эхэндээ их ядарна. Сүүлдээ бие дасаад бүр "гөлийчихдөг". Тэгээд долоо хоног амраад дахиад л ажилдаа гарна шүү дээ. Биднийг зоригжуулдаг байсан зүйл нь "Та нар цэргийн газар ажиллаж байгаа учир хагас цэргийн зохион байгуулалттай байх ёстой. Энэ бол Зэвсэгт хүчний нүүр царай болсон анги учраас ачаалал дааж сур" гэж манай дарга нарын байнга хэлдэг үг байсан. Ер нь бол ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтад гарч байгаа хүмүүсээс дутуугүй, заримдаа бүр илүү ч ачаалалтай байх үе олонтоо. Цэрэг хүний

хийх үйлдэл бүхнийг цаг, минуттай нь нарийн заагаад өгчиддөг болохоор бид ч түүнд нь тохируулж, хоол ундаа бэлтгэсэн байх шаардлагатай. Бид цэргүүдтэйгээ адил майханд байрлаж, гадаа гандаж, хөдөө хөхөрч явдаг ч хэзээ ч гомдоллож байгаагүй. Илүү зүйл ч нэхэж байгаагүй. Энэ бол манай хамт олны ангиа гэсэн чин сэтгэлтэй холбоотой гэж би боддог. Хүн ямар ч ажил хийж болно. Ганцхан түүндээ чин сэтгэлээсээ хандаж чадвал

**Магадгүй би Монголдоо хамгийн олон удаа "Баярлалаа" гэдэг үгийг сонссон хүмүүсийн нэг байх. Байлдагчаасаа эхлээд генерал хүртэл бүгд л надад тэр үгийг хэлээд гардаг нь сайхан. Мөн гадна, дотнын зочдын хөл Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиас тасарна гэж үгүй. Бид чинь Ерөнхийлөгч, төрийн өндөр албан тушаалтнуудаас эхлээд янз бүрийн хүмүүст үйлчилж байсан бөгөөд тэр бүрд хоол, үйлчилгээний чанараа алдалгүй ажиллаж байсан юм.**

эргээд хариу нь ирдэг гэж боддог. Зэвсэгт хүчин хэмээх энэ том "айл"-д ирээд би олон сайхан дурсамжийг бүтээсэн. Үнэхээр сайхан газар шүү.

**Тэгэхээр таны хоолыг идэж үзээгүй цэргийн алба хаагч гэж байхгүй байх нь ээ...**

-Олон жил ажиллахдаа хэдэн мянгаар тоологдох цэргүүдийн хоолыг хийж байжээ.

Заримдаа нийтийн тээврээр үйлчлүүлдэг явж байхад "Та сайн байна уу?" гэж залуус мэндэлдэг юм. Олон хүнд үйлчилж байсан болохоор хүн бүрийн царайг тогтоож чадахгүй шүү дээ.

**Та "Хааны эрэлд" сургуульд олон удаа оролцож, ажиллаж байсан уу?**

-Энэ бол Монгол Улсын Зэвсэгт хүчний жинхэнэ нүүр царай болсон сургууль юм. Өөрөөр хэлбэл, Монголыг дэлхийд таниулж байгаа чухал зүйлсийн нэг гэж боддог. Би "Хааны эрэлд" олон улсын энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургуульд 2006-2013 онд тогоочоор ажилласан. Тэнд голдуу зууш хариуцан ажилладаг байсан. Олон орны цэргийн алба хаагчид ирдэг болохоор аль болох орон, орны онцлогт нь тохирсон хоол хийхийг боддог. Бидний хийсэн хоолыг үнэхээр амт, чанар сайтай гэж хэлэх олон ч гадаадын хүнтэй таарч байсан шүү.

**Тогооч мэргэжлийн сайхан нь юу вэ?**

-Цэргийн алба хэцүү, үргэлж тушаалаар гадаа гандаж, хөдөө хөхөрч явдаг хүмүүс шүү дээ. Тийм болохоор илчлэг сайтай, халуун хоолоор цэргүүдээ хангаж, эрч хүч өгөх нь чухал. Ер нь хооллох гэж ирсэн хүмүүс "Баярлалаа" гэж хэлэхээс бус уурлаад гарна гэж байхгүй. Магадгүй би Монголдоо хамгийн олон удаа "Баярлалаа" гэдэг үгийг сонссон хүмүүсийн нэг байх. Байлдагчаасаа эхлээд генерал хүртэл бүгд л надад тэрхүү үгийг хэлээд гардаг нь сайхан. Мөн гадна, дотнын зочдын хөл Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиас тасарна гэж үгүй.

Бид чинь Ерөнхийлөгч, төрийн өндөр албан тушаалтнуудаас эхлээд янз бүрийн хүмүүст үйлчилж байсан бөгөөд тэр бүрд хоол, үйлчилгээний чанараа алдалгүй ажиллаж байсан юм.

**Зэвсэгт хүчний 011 дүгээр ангид хэзээ ирсэн бэ?**

-Тус ангид 2018 оны 10 дугаар сард ирсэн. Би 1998-2015 онд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид ажиллаад ахынхаа компанид хоёр жил гаруй нягтлан бодогчоор ажилласан. Хүн ер нь ажиллаж сурсан газартаа эргээд хоргодоод байдаг юм билээ. Уг нь хувийн компанид ажиллах нь илүү хөнгөн, цалин хөлс нь өндөр байсан хэр нь надад Зэвсэгт хүчинд ажиллаж байсан минь бодогдоод ер болдоггүй. Нэг л мэдэхэд амьдралын минь баяр, гуниг бүхэн энэ албатай салшгүй холбоотой болчихсон байсан. Үүнийгээ энгийн газар ажиллаад мэдсэн дээ. Тэгээд л нутаг руугаа тэмүүлдэг адуу шиг нягтлан бодогчийн ажлаа хаяад эргээд ирсэн. Цэргийн анги л миний байх ёстой газар юм байна. Энд ирээд номын санчаар ажиллах хугацаандаа интернэт номын санг байгуулсан. Манай анги байнгын бүрэлдэхүүнтэй, инженерийн анги учир номын санд ихэвчлэн мэргэжлийн чиглэлийн ном, гарын авлага эрэлттэй байдаг. Тиймээс номуудын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах үүднээс ийм ажил хийсэн юм.

**Гэр бүлээ танилцуулахгүй юу?**

-Би гурван хүүхэдтэй, том хүү маань замын компанид ажилладаг. Дунд хүү Багахангай дүүргийн Онцгой байдлын ангид дэслэгч цолтой алба хаадаг. Харин охин маань Ерөнхий

боловсролын 6 дугаар ангид сурдаг.

**Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд ажиллаж байсан үеийн тань сэтгэлээс гардаггүй дурсамж юу вэ?**

-Ярьж болдог эсэхийг нь сайн хэлж мэдэхгүй юм. Гэхдээ "Сэтгэлээс гардаггүй дурсамж" гэхээр яалт ч үгүй цэргийн дүрэмт хувцас өмсөөд Зэвсэгт хүчний марш-тактикийн аварга шалгаруулах цогцолбор тэмцээнд гурван жил дараалан оролцож явсан минь хамгийн түрүүнд бодогдож байна. Тодруулбал, 1999-2001 онд оролцож байсан бөгөөд би эмнэлгийн зааварлагч-чиглүүлэгчээр гүйдэг байсан. Тэр үед Хөдөлмөрийн баатар О.Гүндэгмаа надтай нэг тасагт гүйдэг байлаа. Мөн ангийнхаа буудлагын аварга шалгаруулах тэмцээнд оролцоод алтан медаль хүртэж байлаа.

**Таны хүндэлж явдаг хүн хэн бэ?**

-Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид байхдаа би таван захирагчтай гар нийлэн ажилласан. Тэд улсын хэмжээнд Зэвсэгт хүчний нүүр царай болсон ангийг өнгөтэй, өөдтэй авч явах гэж их л хичээдэг байсан. Уурлаж, зандрах үе байлгүй л яах вэ, бүх л юм аясаараа цаанаасаа бүтчихнэ гэж байхгүй шүү дээ. Мундаг ухаантай дарга нараараа би үргэлж бахархдаг. Тэр их ажлыг яаж амжуулж байсныг нь бодохоор их гайхдаг. Мөн надтай хамт ажиллаж байсан манай тасгийн бүсгүйчүүд үнэхээр дайчин байсан шүү.

**Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ**

## Талархал

Миний бие элэгний хатууралтай болсны улмаас ба Улсын нэгдүгээр төв эмнэлгийн элэг шилжүүлэн, суулгах багийн хурлаар хоёр удаа орсон боловч өвчтөн болон амьд донорын элэгний судас нь нэмэлт салаалалттай учир Монгол Улсад хагалгаа хийлгэх боломжгүй, гадаад улсад хагалгаа хийлгэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан юм.

Би 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Бүгд Найрамдах Энэтхэг улсад элэг шилжүүлэх хагалгаанд орсон ба миний бие өдрөөс өдөрт сайжирч байгааг та бүхэндээ дуулахад баяртай байна.

Надад сэтгэл санааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Батлан хамгаалах яам, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Багахангай болон Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, аймгуудын ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 123, 331, 340 дүгээр анги, 116 дугаар тусгай салбар, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүн, зарим ахмад дайчид, Баян-Өлгий аймгийн Аудитын газар, Тагнуулын газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Статистикийн хэлтэс, 1997 онд 10 дугаар анги хамт төгсөгчид, БХИС, Хилийн цэргийн дээд сургуулийн 2001 оны төгсөгчид болон ах дүү, төрөл төрөгсөд, найз нөхдөдөө чин сэтгэлийн талархал илэрхийлж, сайн сайхны ерөөл дэвшүүлье.

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБЫН ТОО БҮРТГЭЛИЙН ОФИЦЕР, ДЭД ХУРАНДАА Н.ТИЛЕК, ЭХНЭР А.ХАРАЛГААШ, ХҮҮ Т.АЙБОЛ, ОХИН Т.НУРДАНА, Т.АЯГӨЗ**

## Гэрэл зураг-нэг агшин



"Сэлэнгэ-2019" хамтарсан сургуулийн үеэр. Гэрэл зургийг ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

**Онч үг**

*Хэрвээ би амьдралд хайртай бол цагийг бүү дэмий үр. Учир нь амьдрал цаг хугацаанаас бүтсэн.*

Брюс Ли



**СОЁМБО СОНИН**

"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,  
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч  
Хурандаа  
Батжаргалын  
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин  
редакцад бэлтгэж,  
"Соёмбо принтинг" хэвлэх  
үйлдвэрт хэвлүүлэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл болон сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018  
И-мэйл хаяг:  
Mil\_newssoyombo@yahoo.com  
Утас: 70001029